

БУЛГАН АЙМАГТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

Булган хот

2010.03.21					
№	Хөтөлбөр төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Биелүүлэх хугацаа	Хяналтан д авсан эвэлт	Хэрэгжилтийн явц	
				Тухайн жилд хийсэн ажлын явц /хувь/	Хөтөлбөр, төсөл хэрэгжинсээс хойш хийсэн ажлын явц /хувь/
A	1	2	3	4	5
А. Үндэсний хөтөлбөр					
Нэг. Төрийн захиргааны чиглэлээр					
1	Хөтөлбөр батлах тухай 2008,01,07 Дугаар 07 /Багийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр/	2008-2015	17	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг 2 дугаар сард газар дээр нь шалгаж эрчимжүүлэх шаардлагатай байгаа талаар 3 сарын 20-ний өдөр аймгийн Засаг даргын албан бичгийг сумдуудад хүргүүлж ажиллаа. Сумдын багийн Засаг дарга нарын нэгдсэн цугларалтыг 5 сарын 1-6-ны хооронд хийж нэгдсэн зөвлөмж гарган хэрэгжилтийг жилийн эцсээр тооцох, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байгаа талаар санал солилцож үнэлэлт өглөө. Эдгээр ажлын үр дүн хэрхэн хэрэгжиж байгаа зөвлөмж хэрэхэн хэрэгжүүлж байгаад үнэлэлт өгөхөөр ажлыг хэсэг бүх сумдаар 7 дугаар сард явж газар дээр нь шалгасан бөгөөд мөн 11 сарын 20-24-ний өдрүүдэд жилийн эцсийн үнэлэлт өглөө. /Хэрэгжилт 100,0 хувь/	"Багийн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхээр аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан гаргасан бөгөөд 3 зорилт бүхий 13 ажил даалгасан ажлын хэсэг томилсон уг хөтөлбөрийг бүх сумдуудад хүргүүлж холбогдох агентлагуудад хүргүүлж ажиллаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах чиглэлээр боловсрол соёлын газар, Цагдаагийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Хүүхдийн төлөө хэлтэс зэрэг байгууллагууд сум орон нутагт ямар ажил зохион байгуулж байгаа талаар орон нутгийн сонин телевизэд ярилцлага өгүүлэн тайланг хагас бүтэн жилээр авч нэгтгэж байна. Аймгийн Засаг даргын тамгын газраас жил бүр багийн Засаг дарга нарын нэгдсэн сургалтыг зохион байгуулдаг бөгөөд дэд хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх ямар арга хэмжээ авах талаар семинар сургалт хийж ажиллаа. Булган аймгийн нийт багийн Засаг дарга нарыг 2008 онд унаагаар /мотоцикл/ хангасан бөгөөд одоогоор хөдөөгийн бүх багийн эмч нарыг унаагаар хангаад байна. Эдгээр арга хэмжээ нь бусад аймгуудтай харьцуулвал анхны багийн Засаг дарга нараа унаагаар хангасан анхны аймаг болсон. /Хэрэгжилт 70,0 хувь/
2	Үндэсний хөтөлбөр батлах тухай 2009,08,012 Дугаар 25 /Гадаад харилцааг эдийн засагжуулах үндэсний хөтөлбөр/			Гадаад харилцааг эдийн засагжуулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний санал авч ажиллаж байна /Хэрэгжилт 10,0 хувь/	Энэ хөтөлбөр 2009 оны 9 сараас эхэлж хэрэгжиж байгаа
Хоёр. Хууль зүйн чиглэлээр					
1	Үндэсний хөтөлбөр батлах, түнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2006.04.03 Дугаар 64 "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх	/2006-2008 2009-2012/		Архивын баримтын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор төрийн архивын 152 хөмрөгийн байнга болон түр хадгалагах баримтын дансыг компьютерт оруулаад байна. Мөн мэдээллийн технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд 2 удаа сургалтанд хамрагдсан. Ажлын нөхцлийг сайжруулах зорилгоор Төрийн архивт 500.000 төгрөгийн засвар хийж, 4320000 төгрөгөөр 9 нягтруулсан тавиур авч 126 хөмрөгийн 4915 баримтыг байрлууллаа. Мөн канон, компьютер, сканнер тус бүр 1 ширхэгийг авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх, мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг Даргын Тамгын газарт албан хэрэг хөтлөлтийн бүртгэл хяналтын программ 1.500.000 төгрөгөөр суулгаж, сургалт зохион байгуулав. /Хэрэгжилт 100,0 хувь/	Аймгийн хэмжээнд 10 сум, 38 байгууллага интернэтэд холбогдсон ба 56 байгууллага дотоод сүлжээ ашиглаж байна. Энэ нь нийт байгууллагын 33,5 хувийг эзэлж байгаа бөгөөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сум, байгууллагын удирдлага жил бүрийн төсөвтөө тодорхой хэмжээний хөрөнгө тусгаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр байгууллагынхаа албан хаагчдын хангах тал дээр анхаарч ажиллаж байна. /Хэрэгжилт 70,0 хувь/

2	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай 2006.11.09 Дугаар 263 /Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр/	2006-2011 2012		<p>Эрх зүйн туслалцааны төв ийн өмгөөлөгчөөс тайлангийн хугацаанд эрүүгийн анхан 34, давж заалдах шатны шүүх хуралд 18, иргэний 3, иргэний давж заалдах шатны 3 хэрэгт тус тус оролцож иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, 58 иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлсэн ба, 18 иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгч ажилласан ба төвийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, тэдгээрт таниулах үүднээс тавдугаар сард аймгийн "Булган" телевизээр 2 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлэг цацаж, "Булганы мэдээ" сонины зургаадугаар сарын хоёр дахь дугаарт ярилцлага өгсөн. Мөн Булган сумын 6 багийн хэсгийн ахлагч нарт "Эрх зүйн туслалцааны төв"-ийн үйл ажиллагаа, "Эрх зүйн хөтөч" номын агуулга, ач холбогдолын талаар сурталчилан ажиллав.</p> <p>/Хэрэгжилт 100,0 хувь/</p>	<p>2008 оны 08 дугаар сарын 01-нээс эхлэн тус Эрх зүйн туслалцааны төв нь төлбөрийн чадваргүй 88 иргэнд өмгөөллийн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж, нийт 80 гаруй иргэд байгууллагад шаардлагатай хууль зүйн мэдээлэл, лавлагаа олгохын зэрэгцээ хууль зүйн анхан шатны зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн ба төрсөн хүүгээ хилсээр шийтгэгдсэн талаар Тэшиг сумын иргэн Д.Долгорын хувийн өргөдлийг Хүний эрхийг хангах үндэсний хороонд хүргүүлэн эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөн ажилласан. Тус төв нь үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш төвийн үйл ажиллагаа, түүний танилцуулгыг байгууллага иргэн, сумдад тогтмол сурталчилан ажилласан болно. Эрх зүйн албан болон албан бус сургалт сурталчилгааны хөтөлбөр боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулахаар бэлтгээд байна. Хууль эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хөдөөгийн иргэд, өрх бүрт хүргэх эрх зүйн мэдээ, мэдээллийн хүрээ баазыг өргөтгөх зорилгоор "Мэдээллийн богц" хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал, төсвийн тооцоо судалгааг хийж байна.</p> <p>/Хэрэгжилт 100,0 хувь/</p>
3	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай 2006.12.27 Дугаар 315	2007-2010	8	<p>Аймгийн ГХУСАЗЗөвлөлөөс цагдаагийн хэлтэст иж бүрэн тоноглолтой хөдөлгөөнт эргүүлийн Х.Верна маркийн суудлын автомашиныг 8,0 сая төгрөгөөр авч өгч, Орхон-Булган аймгийн чиглэлийн хатуу хучилттай замд байнгын пост барих 12 сая төгрөгний хөрөнгийг аймгийн ГХУСАЗЗөвлөл, авто замын сангаас барихаар шийдвэрлэв. 2009 онд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 124 удаа нэгдсэн болон сэдэвт арга хэмжээг 244 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулж, телевизээр 71 удаа, радиогоор 135 удаа хэвлэлээр 12 удаа мэдээ, мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлэг явуулж, 329 удаа ухуулга сурталчилгааны ажлыг явуулж, хэрэг, ослын шалтгаан нөхцлийг арилгуулах талаар 149 мэдэгдэл, шаардлага бичиж хариу авалт 138 буюу 92.6 хувьтай байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тасгийн хэмжээнд сар бүр зохиох нэгдсэн арга хэмжээний хуваарь гаргав. 2009 онд тээврийн хэрэгслийн 256 гэрчилгээг сольж, шинээр 261 тээврийн хэрэгсэлд, өөр аймаг, дүүргийн улсын дугаартай 423 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг сольж БУА дугаар олгож, иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл хүсэлтийг үндэслэн 181 тээврийн хэрэгсэлд шилжл хөдөлгөөний бүртгэл хийв.</p> <p>Хэрэгжилт 90,0 хувь/</p>	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Аймгийн хэмжээнд хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хурлыг жил бүр хийж, хийх ажлын төлөвлөгөө гарган хамтарч ажиллаж байна. Жил бүр тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгийг амжилттай зохион байгуулж, жолооч бэлтгэн гаргаж буй сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллаж байна.</p> <p>/Хэрэгжилт 90,0 хувь/</p>
4	Хөтөлбөр батлах тухай 2007,09,12 Дугаар 225 /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр/	2007-2009 2010-2012 2013-2015	10	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хүчирхийллийн эсрэг салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлийн талаархи мэдээлэл сурталчи лгааны ажлыг аймгийн Цагдаагийн хэлтэс, Шүүх, Прокурор, Хүүхдийн төлөө хэлтэсээс сум байгууллага, иргэдэд тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд бүх сумдад хамтарсан баг байгуулан ажиллуулах ажлыг Дэлхийн зөн ОУБ-ын Булган дахь салбараас зохион байгуулж байна.</p> <p>/Хэрэгжилт 70,0 хувь/</p>	<p>Дэлхин зөн ОУБ-ын Булган дахь салбарын дэмжлэгээр аймгийн Цагдаагийн хэлтэс дээр хамгаалах өрөөг тохижуулан, ор зурагт, сургалт сурталчилгааны материал зэрэг шаардлагатай тоноглолоор хангаж, орон тооны сэтгэл зүйч ажиллуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хүчирхийллийн эсрэг салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлийн талаархи мэдээлэл сурталчи лгааны ажлыг аймгийн Цагдаагийн хэлтэс, Шүүх, Прокурор, Хүүхдийн төлөө хэлтэсээс сум байгууллага, иргэдэд тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд бүх сумдад хамтарсан баг байгуулан ажиллуулах ажлыг Дэлхийн зөн ОУБ-ын Булган дахь салбараас зохион байгуулж байна.</p> <p>/Хэрэгжилт 50,0 хувь/</p>
5	Монгол Улсад бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр батлах тухай 2008.02.27 Дугаар 78	2008-2012	24	<p>Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс онлайн сүлжээнд холбогдсон бөгөөд бүх төрлийн лавлагаа, үйлчилгээ улсын нэгдсэн бүртгэлийн сангаас олгогдох боломж бүрдсэн. 2008 оноос шилэн кабельд холбогдсон сумдыг сүлжээнд холбох зорилт тавьсан боловч аймгийн төвийн Булган суумаас бусад сумдыг холбох техник эдийн засгийн нөхцөл бүрдээгүй байна. Аймгийн Засаг даргын захирамжаар Улсын бүртгэлийн хэлтэс зохион байгуулагдаж, иргэн, хуулийн этгээд, өмчлөх эрхийн улсын бүртгэлийг нэгдгээр үзүүлэх боломжийг бүрдүүлээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг хуульд заасны дагуу хагас жилд нэг удаа явуулж, дахин үнэлгээ хийж тайлан мэдээг хугацаанд гаргаж ажиллаа. Өмчийн асуудал хариуцсан орон тооны мэргэжилтэн ажиллуулж байна.</p> <p>/Хэрэгжилт 90,0 хувь/</p>	<p>Сум, багийн албан ёсны нэршлийн судалгааг авч, иргэний үнэмлэхний хаягийн тэмдэглэлд багийн албан ёсны нэршилээр шивилт хийж хэвшээд байна. Иргэний үнэмлэх, баримт бичгийн нэгдсэн дугаарын танилцуулгыг сумдын удирдлага болон байгууллагуудын дотоодын сургалтын цагуудаар нийтэд сурталчилж 500 гаруй иргэдийг хамруулж, иргэн, хуулийн этгээд, өмчлөх эрхийн улсын бүртгэлийг эрхлэн явуулах бүтцийг орон нутагт нэгтгэн зохион байгуулж, үйл ажиллагаа явуулах боломж нөхцөлөөр хуулийн хүрээнд дэмжиж байна. бүх сумдад бүртгэлийн ажилтан орон тоогоор ажиллуулж, нэгдсэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>/Хэрэгжилт 90,0 хувь/</p>

6	Автлгалтай тэмцэх үндэний хөтөлбөр		<p>Авлигатай тэмцэх, тэдгээртэй холбоотой хууль тогтоомжуудыг байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдэд сурталчилах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, түүнтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүнд суртал, чирэгдэлийг таслан зогсоох, төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэд олон түмэнд нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор Аймгийн ИНБ-уудын зөвлөлийг байгуулан, тэдгээртэй хамтран ажиллах "Авлига түүнтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 2009 онд хамтран ажиллах төлөвлөгөө"-г батлуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж биелэлт 90 хувьтай байна</p> <p>НҮБ-аас жил бүрийн 12 дугаар сарын 09-ний өдрийг Авлигатай тэмцэх олон улсын өдөр болгон зарласантай холбогдуулан 11 дүгээр сарын 16-наас эхлэн "Шударга ёсыг эрхэмлэе, хүнд суртал авлига түүнтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлье" сэдэвт сарын аян зохион байгуулан ажилласан. Мөн зургадугаар сард Авлигатай тэмцэх газарын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан Ж.Төмөрхуяг төр захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан, нягтлан бодогч нийт 90 гаруй хүнд "Өнөөдрийн хүнд суртал маргаашийн авлигын үндэс, Байгууллагын ил тод байдал, Байгууллагын түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөлт" сэдвээр сургалт хийлээ</p> <p>2008 оны байдлаар 292 төрийн захиргааны албан тушаалтаны хөрөнгө орлогын мэдүүлийг хуулийн хугацаанд гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлээ Авлигатай тэмцэх газраас ирсэн "хяналт, шинжилгээ үнэлгээний ажлын хэсгээс өгсөн заавар зөвлөмжийн дагуу "Нууцын тэмдэг ийг Улаанбаатар хотын "Тод тамга" ХХК-д захиалан 26000 төгрөгөөр захиал ашиглаж байна.</p> <p>/Хэрэгжилт 100,0 хувь/</p>	<p>Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын үүдэнд туснай санал асуулгын хуудас бэлдэн иргэдээс санал асуулга авч ажиллаа. Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, саналыг хүлээн авч нэгтгэн дүгнэж авилгалын эсрэг сургалт сурталчилгааг зохион байгуулж санал дүгнэлт гарган ажилласан. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсээс "Хуулийн цаг" нэвтрүүлгийг 2009 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Лхагва гариг бүр нэг удаагийн давтамжтайгаар нэвтрүүлэг бэлтгэн гаргалаа. Үүнд төсөв, санхүүгийн ил тод байдлыг сар бүр тайлагнан хэвшиж байгууллага бүрийн үйл ажиллагааны нээлттэй ил байдлыг сурталчилан ажиллав. Тус нэвтрүүлгээр аймгийн хэмжээнд гарч буй гэмт хэргийн гаралт, хэргийн илрүүлэлт, хуулийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгох, Албан тушаалтны гэмт хэрэг, авилгалтай тэмцэх чиглэлээр сурвалжлага, "Авилгал холоос биш ойроос ирнэ" гэх мэт сурвалжлага, эрэгцүүлэмжийг бэлтгэн явуулав. Мөн хууль зүйн сурталчилгааны материал бэлтгэх, нэвтрүүлэх, иргэдийн санал хүсэлтийг сонсох, хүлээн авах хайрцаг, санал, хүсэлтийн дэвтэр ажиллуулах, Иргэдийн дунд ихэвчлэн гарч байгаа гэмт хэргээр түүвэрлэн сэрэмжлүүлэг хийлээ. Үүний зэрэгцээ сумдын телевизүүдтэй хамтран ажиллаж заавар чиглэл өгч "Авлига доод шатнаас эхлэнэ" нэвтрүүлгийг бэлтгэн явуулсан болно. Хөтөлбөрийн хүрээд эрх зүйн сургалт, сурталчилгааг 2 суманд болон Булган сумын төрийн болон төрийн бус аж ахуйн нэгжээр зохион байгуулахаар төлөвлөсөн ба төлөвлөгөөний дагуу 1 дүгээр улиралд Аймгийн ИТХ, ГХУСАЗЗ, Ажил олгогч эздийн холбоо, Иргэний нийгмийн байгууллагын Зөвлөл хамтран "Авлига түүнтэй холбоотой гэмт хэрэг, хүнд сурталаас" урьдчилан сэргийлэх зорилготойгоор 2009 оны 1 дүгээр сарын 22-нд сумын Засаг дарга, тамгын газрын дарга, бусад агентлаг хэлтсийн дарга,</p> <p>/Хэрэгжилт 100,0 хувь/</p>
7	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр		<p>Аймгийн хүний эрхийг хангах салбар хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2009 оны 70 дугаар тогтоолоор батлуулан салбар хорооноос 2009 онд хийж гүйцэтгэх ажилаа төлөвлөн ажиллаж төлөвлөгөөний биелэлт 71.03 хувьтай байна. Мөн Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооноос эрхлэн гаргасан хүний үндсэн эрх, эрх чөлөөний талаар бэлтгэсэн цуврал нэтрүүлгийг "Булган" ТВ-ээр нэвтрүүлж эхлээд байна. Жил бүрийн 10 дугаар сарын 10-ны өдөр нь дэлхий нийтээр "Цаазаар авах ялын эсрэг өдөр" ба энэ өдөртэй холбогдуулан дэлхий нийтэд авч хэрэгжүүлж байгаа мэдээ, мэдээллийн талаар аймгийн "Булган телевиз", "Булганы мэдээ" сониноор дамжуулан сурталчилан ажилласан. 12 дугаар сарын 10-ны өдөр буюу хүний эрхийг хамгаалах өдөр аймгийн Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран хууль хяналтын байгууллагуудыг оролцуулсан "Хүний эрх" мэдээлэл, сурталчилгааны өдөрлөг зохион байгуулан мэдээллийн өртөө аялуулан Булган сумын 6 багийн хэсгийн ахлагч, иргэдэд сурталчилан байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчилан, сургалт сурталчилгааны материал тараан ажиллаж 2009 оны тайланг хэлэлцэж хойшид хийгдэх ажилаа төлөвлөн хэлэлцүүлэг хийлээ. Хууль эрх зүйн мэдээлэл сурталчилгааны "Хуулийн цаг" нэвтрүүлгийг аймгийн "Булган телевиз"-тэй хамтран долоо хоног бүрийн Лхагва гараг бүр нэвтрүүлж 2009 онд 10 дахь хөтөлбөрөө нэвтрүүлээд байна.</p> <p>/Хэрэгжилт 100,0 хувь/</p>	<p>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр НҮБ-ийн санхүүжилтээр хэрэгжиж байсан тусдаа орон тоо бүхий мэргэжилтэн ажиллахаа больсноор сумдад хүний эрхийг хамгаалах ажил зогсонго байдал орж, тодорхой хариуцсан ажилтан албан тушаалтан, мэдээллийн самбар байхгүй болсон. Цаашид хүний эрхийг хангах чиглэлээр аймаг, сумын хэмжээнд салбар хороо байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 01/506 тоот албан бичиг хүргүүлэн ажилласан. Сумдад хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжуудын эмхтгэл, гарын авлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага боловсруулан хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийслэлийн Цагдаагийн газар, Хууль зүйн үндэсний төв, Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сангаас эрхлэн гаргасан амьдралдаа алдаж гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүийн хувь заяа, хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүүхдэд хүлээлгэж буй эрүүгийн хариуцлагын талаар "Надад хүүхэд нас байгаагүй" баримтат кино, "Хүний эрх" зэрэг баримтат кино аймгийн Булган телевиз, MDCH телевизээр тус бүр 2 удаа гарган сурталчилсан.</p> <p>/Хэрэгжилт 100,0 хувь/</p>

Гурав. Батлан хамгаалах чиглэлээр					
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2006.10.11. Дугаар 304 /Зэвсэгт хүчний байгууллагыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр/	2006-2010 2011-2015	15	Зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны ойн баярыг аймгийн хэмжээнд тэмдэглэхдээ зэвсэгт хүчний хууль тогтоомж болон дүрэм журам заавруудыг сурталчилах олон нийтэд таниулах арга хэмжээ ав 10 жилийн 1, 2-р сургуулиуд дээр сурталчилгаа хийж ажилласаны дээр хүчний байгууллагуудын дунд "Марш тактик"-ийн тэмцээнийг аймгийн Засаг даргын нэрэмжит болгон явууллаа. Тус тэмцээнд ОБХэлтсийн хамт олон тэргүүн байр эзэлсэн бөгөөд ирэх 2010 онд Хорих 439-р анги марш тактикийн тэмцээнийг хариуцан зохион байгуулж явуулах цаашлаад хүчний байгууллагууд ээлж дараатайгаар зохион байгуулахаар тохиролцооло. /Хэрэгжилт 100 хувь/	"Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"- ийн хүрээнд хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг сурталчилах ажлыг өргөн далайцтай явуулж энэ арга хэмжээнд аймаг, сумдын 2000 гаруй иргэд, хөдөлмөрчдийг хамрууллаа. Орон нутгийн бололцоог ашиглан Цэргийн үүрэгтний сургалтын төв байгуулан одоогийн байдлаар 1,2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэд, бэлтгэл офицеруудын сургалтыг зохион байгуулж нийт 540 гаруй цэргийн үүрэгтэн хамрагдаад байна. Сургалтын төвийн тохижилт, үзүүлэн таниулах материал, зурагт болон бичмэл самбар 20 гаруйг бэлтгэж сургалт явуулах бололцоо нөхцлийг сайжрууллаа. /Хэрэгжилт 90,0 хувь/
Дөрөв. Санхүү, эдийн засгийн чиглэлээр					
Тав. Нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр					
1	Хөтөлбөр батлах тухай 2000,05,22 Дугаар 72 /Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үндэсний хөтөлбөр/	2000 оноос	4	2002 оноос эхлэн Булган сумын өрхийн 3 эмнэлэгтэй Сумын засаг дарга, Эрүүл мэндийн газрын орлогч дарга,Өрхийн эмнэлгийн ахлагч нарын гурвалсан гэрээ байгуулан ажиллаж Булган сумын хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна . Жилийн эцэст гурвалсан гэрээний биелэлтийг иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн ажилладаг. 2000 оноос эхлэн "Энх- Үрс", "Цанлиг","Ман-Од","Сожд" ХХЭ-үүд АНЭ-тэй гэрээ байгуулан хог хаягдлыг цуглуулах устгах, эмнэлгийн багаж хэргэсэл, ороох боох материалыг ариутгах, лабораторийн шинжилгээ хийх, эмч нарын зөвлөгөөн хийхэд зөвлөх эмчийг оролцуулах, алсын дуудлагад ХХЭ-ийн эмч нарыг явуулах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлж байгаа нь хоёрдугаар шатлалын эмнэлгийн тусламжийн чирэгдэл, хүндрэл, ачааллыг тодорхой хэмжээгээр бууруулсан. / Хэрэгжилт 90,0 хувь/	2002 оноос эхлэн Булган сумын өрхийн 3 эмнэлэгтэй Сумын засаг дарга, Эрүүл мэндийн газрын орлогч дарга,Өрхийн эмнэлгийн ахлагч нарын гурвалсан гэрээ байгуулан ажиллаж Булган сумын хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна . 2000 оноос эхлэн "Энх-Үрс", "Цанлиг", "Ман-Од", "Сожд" ХХЭ-үүд АНЭ-тэй гэрээ байгуулсан. /Хэрэгжилт 90,0 хувь/
2	Зайны сургалтын үндэсний хөтөлбөр батлах тухай 2002,01,25 Дугаар 14	2002-2003 2004-2007 2008-2010	5	2009 оны байдлаар 5 удаа зайн сургалтын конференцийг хүлээн авч энэ хурал, сургалтанд давхардсан тоогоор 100 гаруй хүн хамрагдлаа. БСШУЯ, АББЗСҮТ-тэй хамтран 2010 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Тус аймгийн 5 суманд "Чех Каритас" төслийн хүрээнд зайны сургалтын богино долгионы станц 10-ыг суурилуулж , сургалтанд ашиглаж эхэллээ. Зайны сургалтын чиглэлээр СӨБ-ын багшийн 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Хэрэгжилт 100,0 хувь /	БСГ-т зайны сургалт зохион байгуулах техник хэрэгслийг суурилуулсан. БСГ-ын Гэгээрэл мэдээллийн төвд зайн сургалтын чиглэлээр багш нарын заах арга зүй, компьютер сургалт, гадаад хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр 30 гаруй төрлийн CD, DVD, электрон хичээлийн сан бүрдүүлсэн. /Хэрэгжилт 90,0 хувь /
3	Хөтөлбөр батлах тухай 2002,05,15 Дугаар 92 /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр/	2002-2005 2006-2010	10	Хөдөлмөр эрхлэлтийн талаар аймгаас баримтлах бодлогыг батлуулан, хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлт ажилгүйчүүдийн бүртгэлд 2009 онд 2392 хүн бүртгэгдснийг ажилд зуучлах, байнгын болон улирлын ажлын байраар хангах арга хэмжээг авлаа. Үүнд: Ажил олгогчдоос ирүүлсэн 1024 ажлын байрны захилгад 1185 хүнийг зуучлан, шинээр бий болгосон байнгын ажлын байранд 820 хүнийг, улирлын ажлын байранд 365 хүнийг ажлын байраар хангаж ажиллаа. Хэрэгжилт 90,0 хувь/	Хөдөлмөр эрхлэлтийн талаар аймгаас баримтлах бодлогыг батлуулан, хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлт ажилгүйчүүдийн бүртгэл мэдээллийн сан байгуулан ажилд зуучлах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Хэрэгжилт 95,0 хувь/
4	Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2002,06,28 Дугаар 129	2002-2010	5	2009 оны 0-1 насны хүүхдийн тарилгын хамралт: БЦЖ- 98.5%, Халдварт саа- 98.3%, Тавт - 98.2%, Улаанбурхан-97.7%, В гепатит- 98.7%, УГУ-100% нийт хамралт 98.4 % байна.Сүрьеэ өвчний оношийн баталгаажилт 2008 оноос сайжирч эрт илрүүлэлт нэмэгдсэн.4 суманд Нээлттэй хаалганы өдрийг "Сүрьеэ өвчнөөс сэргийлье",Сүрьеэ өвчнөөс сэргийлье" уриан дор зохион байгууллаа.ГХӨ-өөс сэргийлэх урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг 5 сумын 32 байгууллага нийт 619 хүнд хийж, "Булганы мэдээ", орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа, сэрэмжлүүлэг явуулсан. ВГА-ийн 198 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 37 тохиолдлоор буурсан.БГХӨ-тэй тэмцэх мэргэжлийн баг Булган, Баяннуур сумын нутагт гарсан голомтонд ажиллаж халдваргүйтгэл, сурталчилгаа хийсэн. 2009 онд томуугийн харуулдан тандалтын 4 нэгжтэй болсон нь өвчний гаралтыг хянах, вирусын эргэлтийг лабораториор оношлуулахад ая холбогдолтой болж мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон. / Хэрэгжилт 90,0 хувь/	Сүүлийн 2002-2009 онд заавал хийх дархлаажуулалттай халдварт өвчин бүртгэгдээгүй байна.Сүрьеэгийн диспансерийн хяналт, оношийн баталгаажилт 71,4%,эдгэрэлтийн хувь 92,3 болж дэвшүүлсэн зорилтонд хүрсэн.Булган аймгийн хэмжээнд 2002-2009 онд халдварт өвчин 10000 хүн амд 6,7-13,2 бүртгэгдсэн байна.ВГА-ийн өвчлөл аймгийн хэмжээнд буурсан.Бүрэгхангай, Орхон, Баяннуур, Хишиг-Өндөр сумдын байгалийн голомтот халдварт өвчний голомтонд давтан өвчлөл гараагүй. Эмнэлгээс шалтгаалах халдварыг илрүүлэх халдвар хяналтын зөвлөл АНЭ, СДЭ, сум болон өрхийн эмнэлгүүдэд ажиллаж байна АНЭ,Сум,ӨЭ-д 2002-2009 онд заавал хийх дархлаажуулалттай халдварт өвчин бүртгэгдээгүй байна. Эмнэлгийн дотоод халдвар гараагүй. /Хэрэгжилт 90,0 хувь/

5	Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай 2002,12,04 Дугаар 245	2002-2004 2005- 2007 2008-2010	6	Өсвөр үе залуучуудад ардчилсан, эх оронч үзэл, үндэсний уламжлал, хэл соёл, зан заншлыг төлөвшүүлэх зорилгоор Хүүхдийн "Нүүдэлчин клуб", Хүүхдийн парламентын хүүхдүүд "Монгол хүү- Малчны хотонд" 4 сарын аяныг зохион байгууллаа. Аймгийн Хүүхдийн Парламентийн хүүхдүүдийн санаачлагыг дэмжин хүүхэд өсвөр үеийнхэнийг чадваржуулах, баг хамт олноор ажиллах чадварыг дээшлүүлэх, амьдрах ухаанд сургах зорилгоор «Майханта зуслан- Хүүхдийн солонго урлагийн наадам»-ыг Хангал сумын Галтайн амралтанд зохион байгууллаа. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоох өдрийг тохиолдуулан эцэг эхчүүд, хүүхдүүдэд "Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргууд" цуврал сургалтыг Булган хотод зохион байгуулж 20 гаруй байгууллагын 335 иргэнд сурталчилгааны материал өгч, хүүхэд гэр бүлийн орчинд төлөвших таатай орчин бүрдүүлэх талаар эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж байна. /Хэрэгжилт 100,0 хувь/	Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтыг гарган дүгнэлт хийж 2009 онд Аймгийн ИТХТ-ийн хурлаар " Хүүхдийн хөгжил хамгааллыг 2009-2012 онд сайжруулах үндсэн чиглэл"-ийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. /Хэрэгжилт 100,0 хувь/
6	Хөтөлбөр батлах тухай 2002,12,13 Дугаар 251 /Рашаан сувилалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2003-2006 2007- 2010	4	Асгатын рашааныг хими, бактериологийн шинжилгээнд хамруулж 200м талбайд хамгаалалтын бүс тогтоож тохижуулсан. Хүн амд рашаан сувиллыг чанартай үйлчилгээг хүртээмжтэйгээр үзүүлж байхын тулд Адаг нугын рашаан болон газрыг дуудлага худалдаанд оруулсан. Хужирбулангийн рашааныг нөхөн сэргээх болон УАУ-ын эмчилгээтэй хавсран ард иргэдэд хэрэглэж байна. Рашаан сувилалд нийт 1974 хүн хамрагдсан. Нийт 2189 хүнд рашаан сувиллын талаархи мэдлэг хандлагыг дээшлүүлэх чиглэлээр сургалт явуулж сурталчилгааны материал тарааж, рашаан сувиллыг хамгаалах орчныг бохирдуулахгүй байх, ариун цэврийг сахиж, рашаан сувиллыг эмчигээнд хэрэглэхийн ач тусын ойлголтыг багтсан сургалтыг явуулсан. Мөн санамж, сэрэмжлүүлгийг байрлуулж мэргэжлийн зөвөлгөө өгсөн. / Хэрэгжилт 90,0 хувь/	Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд зарим рашааны бүтэц найрлагыг нарийвчлан тогтоон рашаан сувиллын ордыг паспортжуулж, орон нутгийн нутгийн хэмжээнд ашиглагдах рашааны ундаргыг судлан, рашааны усны нөөцийн судалгааг хийж рашааны ашиглалт, хамгаалалтын дүрмийг ИТХ-аар оруулж батлуулан ажиллаж байна. Адаг нуга, Баруун могойн овоот, Хужиртын рашаан, Хавцгайтын рашаан, Хужирбулангийн рашаан, 4-р багийн хүрхрээ, Хануй рашаан, Цагаан голын рашаан зэрэг рашаануудад ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоосон байна. / Хэрэгжилт 90,0 хувь/
7	Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай 2002,12,30 Дугаар 274	2003-2004 2005- 2008 2009-2012 20013- 2015	15	2009 онд ХЯБХ-ийн "Эмэгтэйчүүд хөгжил" дэд хэсгийн бичил санаачлагыг дэмжих "Бичил зээлийн чиглэлээр Өөртөө туслах бүлэг" байгуулах сургалтыг нийт 16 сум 1 тосгонд зохион байгуулж 550 гаруй эмэгтэйд хамрууллаа. Мөн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах тэднийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, "Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зам " сэдвүүдээр Орхон, Баяннуур, Могод, Сайхан, Хишиг-Өндөр, сумдад зохион байгуулж нийт 400 гаруй эмэгтэйчүүдийг сургалтанд оролцуулав. Бичил зээлийн чиглэлээр бүлэг байгуулах сургалтыг 16 суманд зохион явуулснаас Хутаг-Өндөр, Баян-Агт, Булган, Дашинчилэн, Бүрэгхангай, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумдад идэвхитэй сайн зохион байгууллаа. Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөрыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үлгэр жишээ шилдэг гэр бүлүүдийн туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд "Тэнгэрлэг гэр бүл " шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж 54 гэр бүлийг шалгаруулан оролцуулав. Хэрэгжилт 90,0 хувь/	"Жендерийн тэгш байдлыг хангах" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын 184 дүгээр захирамжаар баталгаажуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Сумдын Засаг даргын тамгын газрын асуудал эрхэлсэн ажилтны семинарыг жил бүр зохион байгуулж тэдэнд гарын авлага, зөвлөмж, эмхэтгэл боловсруулж хүргүүлж байна. Хэрэгжилт 90,0 хувь/
8	Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай 2004,12,22 Дугаар 244	2004-2008 2009- 2012	4	Хүн амын боловсролын болон бичиг үсгийн боловсролын түвшний судалгааг 2010 оны хүн амын тооллогоор шинэчлэн гаргахаар төлөвлөж байна. 2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 271 бичиг үсэг үл мэдэгч байгаагаас 52 хүнийг бичиг үсгийн сургалтад хамрууллаа. Хэрэгжилт 100 хувь	Жил бүр бичиг үсэг үл мэдэгч иргэдийн судалгааг гаргаж сургалтанд хамруулж ирсэн. Хөтөлбөр батлагдсанаас хойш нийт 200 гаруй хүнийг хүнийг бичиг үсгийн боловсролтой болгосон. Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөртэй хамтран 23 явуулын багш бэлтгэж тэдний ажлын үр дүнгээр нь урамшуулал олгож ирсэн. 2002 онд 728 хүн бичиг үсгийн боловсролгүй байсан бол энэ тоо 2006 онд 428 болж буурсан бол 2009 оны байдлаар 219 болоод байна. Хэрэгжилт 100 хувь
9	Үндэсний хөтөлбөр батлах тухай 2005,03,09 Дугаар 43 /Морин хуур уртын дуу үндэсний хөтөлбөр /	2005-2014	3	Хангайн бүсийн 5 аймгийн уран сайханчдын дунд зохиогдсон уртын дууны уралдаанд тус аймгаас 4 насны ангилалд уртын дуучид оролцон, Дашинчилэн сумын ардын авъяастан Ц.Дондоо тусгай байрын шагнал хүртлээ. Хишиг-Өндөр суманд Морин хуурын бие даасан чуулга байгуулагдах анхны бие даасан тоглолтоо хийлээ. Нутгийн уртын дууг сурвалжлан олох талаар арга хэмжээ авч 3 дууг шинээр сурвалжлан олж бүртгээд байна. /Хэрэгжилт 100,0 хувь/	Аймгийн дэд хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж байна. Сум бүрт Морин хуурын дугуйлан ажиллаж жилд 5-8 хүүхэд хамрагдаж ирсэн. Хишиг-Өндөр суманд морин хуурын чуулга байгуулсныг дэмжиж аймгаас 10 морин хуур олгосон. Байгууллага бүр морин хууртай болсон. Жил бүрийн Цагаан сарын Шинийн гурванд морин хуур цэнгүүлж хэвшээд байна. /Хэрэгжилт 70,0 хувь /

10	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай 2005.04.13 Дугаар 75 "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр"	2005-2007 2007-2010	6	"Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн аймгийн салбар зөвлөлийг 2009 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2009 оны 100 тоот тогтоолоор байгуулан дүрэм, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлж эхэллээ. Мөн сумдад салбар зөвлөл байгуулан ажиллуулж байна. /Хэрэгжилт 90,0 хувь /	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн аймгийн салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна. /Хэрэгжилт 90,0 хувь/
11	Халдварт бус өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр батлах тухай 2005.12.14 Дугаар 246	2006-2009 2010-2013	3	Долоо хоногийн 4 дэх өдрийг Гаригын сургалтын өдөр болгон, хөдөлгөөнт болон захиалгат сургалтыг 7 байгууллага, Хишиг-Өндөр, Сайхан сумдад зохион байгуулж нийт 380 хүнд, 1-р 11 жилийн сургууль, ЭӨЦС-ийн 1-11 ангийн эрүүл мэндийн идэвхтэн 156 сурагчдад, "Зөв хооллолт", "Хөдөлгөөн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх", "Хорт зуршлаас сэргийлэх" сургалт, БТСХороо, Спортын дунд сургуулийн 23 багш ажилчдад "Хүнсний аюулгүй байдал", "Урт наслахын увидас" зэрэг сэдвүүдээр сургалт хийж гарын авлага материалаар хангалаа. Эрүүл мэндийн туслагч нарт 25 удаа 13 төрлөөр сургалт хийж давхардсан тоогоор 6776 хүнийг хамруулсан. Биеийн тамир чийрэгжүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд нийтийн биеийн тамирыг сурталчилах ажлын хүрээнд нийт 15600 хүнд мэдээлэл өгч сургалтыг 96 удаа хийж 14006 хүн хамруулан 37821 сурталчилгааны материал тараасан байна. Хүүхдэд "Хөдөлгөөн эрүүл мэнд" сургалтыг 10 удаа хийж, сургуулийн насны хүүхдийн 37 удаагийн уралдаан тэмцээнд 3081 хүүхдийг хамарчээ. Хүн амыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн болон насанд хүрэгчид иргэд олон нийтийг хамарсан 209 удаагийн 14009 хүнийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулж шагнаж урамшууллаа. Аймгийн хэмжээнд "Биеийн тамир-эрүүл мэнд" аяны хүрээнд 63 албан байгууллага аж ахуйн нэгжийн 892 ажиллагсадаас ББХТТСорил аван үнэлгээ өгөхөд хангалтгүй /D, F/ үнэлгээ 58.5%, ба 41.5% хангалттай /A, B, C/ үнэлгээтэй. Ажлын байранд хийх дасгал, бүх нийтийн гүйлт, алхалтын тэмцээнд 3320 хүн хамрагдсанаар хөдөлгөөний идэвхи нэмэгдсэн. 16 сумын биеийн тамир чийрэгжүүлэлт хариуцсан арга зүйч, 13 байгууллагын нийтийн биеийн тамир нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт сургалт хийлээ. /Хэрэгжилт 90,0 хувь/	Аймгийн нийт хүн ам /58327/-аас биеийн хүч бага шаардсан хөдөлгөөн хийдэг 7318 хүн, чөлөөт цагаараа биеийн хүч их болон дунд зэрэг шаардсан хөдөлгөөн хийдэг 18496 хүн, биеийн хүч их болон дунд зэрэг шаардсан хөдөлгөөн хийдэг 8626 хүн, ажлын байрандаа дасгал хөдөлгөөн хийдэг 9732 хүн, 7 хоногийн ихэнх өдөр 30 минутаас доошгүй хугацаагаар идэвхитэй хөдөлгөөн хийдэг 23524 хүн, илүүдэл жинтэй 1882 хүн байна. Аймгийн хэмжээнд 71 байгууллагын 1067 хүнд ажлын байрны дасгал болон хийн дасгал хөдөлгөөнийг зааж сургаснаар ажилчид ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшээд байна. Хүн амын тамхины хэрэглээний түвшин 51,0%. Согтууруулах ундаа хэрэглэдэг хүний түвшин 63,4%. Үүний 50% нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэгч, 4% нь тогтмол хэрэглэгчид байгаа нь халдварт бус өвчнөөр өвчлөх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Умайн хүзүүний хорт хавдар оношлогдсноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь 35,1 Хөхний хорт хавдар оношлогдсноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь 33,3 Нас баралтын үзүүлэлт Тархины цус харвалтаас шалтгаалсан нас баралт 10000 хүн амд 12,4, Зүрхний шигдээсийн улмаас нас баралт 10000 хүн амд 3,3, Хорт хавдараас шалтгаалсан нас баралт 10000 хүн амд 14,5 /Хэрэгжилт 50,0 хувь/
12	Амны хөндийн эрүүл мэнд, үндэсний хөтөлбөр батлах тухай 2006.06.28 Дугаар 150	2006-2010 2011-2015	3	Ихэнх сумдын усны хатуулаг ихтэйгээс хамаарч өвчлөл буурахгүй байна. Ундны усан дахь фтортын агууламжийг тодорхойлуулахаар Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр сумын худгуудаас усны дээж авч шинжилгээнд явуулахад Хишиг-Өндөр сумын усны фторын агууламж хэвийн хэмжээнээс өндөр гарсан. Орхон, Дашинчилэн, Гурванбулаг сумдад УБ хотоос, Сэлэнгэ, Бугат, Хангал, Хялганат сумдад Орхон аймгаас тус тус эрүү нүүрний эмч урьж ажиллуулан явуулын үйлчилгээг хүргэж байна. /Хэрэгжилт 70,0 хувь/	АНЭ-т нүүр ам судлалын 2 эмч, Хишиг-Өндөр суманд 1 эмч ажиллаж орон нутгийн иргэдэд шүдний тусламж үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн хэмжээнд шүд цоорох өвчний тархалт 23.1%, шүд цоорох өвчний эрчим 2.3%, бүрэн шүдтэй 18 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувийн жин 31% байна. /Хэрэгжилт 90,0 хувь/
13	Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлах тухай 2006.11.21 Дугаар 282	2007-2008 2009-2012 2013-2015	24	"Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийн зорилт, зорилго хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сумдын ЗДТГ, ЕБС-ийн нийгмийн ажилтан, хүүхэд, залуучуудын ТББ-ын идэвхтэн сонгуультан, холбогдох хэлтэс, агентлагийн ажилтнуудыг оролцуулсан сургалт, семинар зохион байгуулж тодорхой аргачлал, гарын авлага, материал өгч ажиллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль хяналтын байгууллага, ТББ, төсөл хөтөлбөрийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулж байна. /Хэрэгжилт 90 хувь/	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль хяналтын байгууллага, ТББ, төсөл хөтөлбөрийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулж байна. 2008 оныг "Залуучуудыг дэмжих жил" болгон зарлаж тусгай удирдамж төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн "Залуучуудыг дэмжих жил"-ийн ажлыг дүгнэж ажилласны дээр "Аймгийн залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. /Хэрэгжилт 90,0 хувь/
14	Хөтөлбөр батлах тухай 2006.11.21 Дугаар 283 /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр/	2006-2008 2009-2012	11	Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 258 байгаа бөгөөд Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамт олны нь дунд сургах, төлөвшүүлэх талаар ярилцлага явуулж "Хариу нэхээгүй тус" аян зохион байгуулж өөрт илүүдэлтэй байгаа эд зүйлсийг цуглуулах, хичээл сургалтанд нь туслах, хэвтрийн өвчтэй иргэдэд гэрийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг жил бүр уламжлал болгон явуулж энэ арга хэмжээнд 60 хүн хамрагдлаа. Хөгжлийн бэрхшээлтэй 80 гаруй хүүхдэд нөхөн сэргээх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. /Хэрэгжилт 90,0 хувь/	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар сумдын Засаг даргын тамгын газар, холбогдох төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тодорхой чиглэл өгч хэрэгжүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан түүнд шаардагдах зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. /Хэрэгжилт 95 хувь/

15	"Нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний гурав дахь хөтөлбөр батлах тухай 2007.03.07 Дугаар 52	2007-2011	6	Сум ба нэгжийн ирүүлсэн захиалганд үндэслэн Сайдын тушаалаар ирсэн 9 нэр төрлийн 12сая 225587 төгрөгийн жирэмснээс хамгаалах эм хэрэгсэл,эх барихын нэн шаардлагатай эмүүдийг хувиарлав. НЭ-ийн төрөх тасагт О2 өтгөрүүлэгч аппарат, суурин кварц, хатаах шүүгээ ДЗОУБ-с олгогдсон.НҮБ/ХАС-аас электрокардиограммын аппарат 2ш, фургон автомашин ирсэн. Аймгийн хэмжээнд 1700 эх жирэмсний хяналтанд орсон ба 92.6% БЗДХ /ХДХВ /ДОХ.90.9% тэмбүүгийн шинжилгээнд хамрагдсан. Сумдуудад түргэчилсэн оношлуураар ХДХВ /ДОХ, тэмбүүгийн шинжилгээ хийгдэж байна.Бүх сум, өрхийн эмнэлгүүдэд үнэ төлбөргүй бэлгэвч тараагдаж, зөвлөгөө өгч, ДОХ/ХДХВ/БЗДХ-ын кабинетад үнэ төлбөргүй түрхэцийн шинжилгээ 2245 хүнд хийж, өвчтэй илэрсэн 728 хүнийг эмчилсэн. / Хэрэгжилт 90,0 хувь/	15 сум эхчүүдийн амрах байрыг тохижуулан амарвал зохих эхчүүдийг амрааж байна.Жирэмсэн эхчүүдийн 70% АНЭ-д төрсөн. Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөнд 187,3. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 18,7. Перинаталь эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 12,3 Жирэмсний эрт үеийн хяналт 87,7%, БЗДХ /ХДХВ /ДОХ-ийн шинжилгээнд 92,0% хамрагдсан.Тэмбүүгийн шинжилгээд 90.9% хамрагдсан. / Хэрэгжилт 90,0 хувь/
16	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай 2007.06.20 Дугаар 150	2007-2012	4	2009 аймгийн Засаг даргын захирамжаар сондгой сарын барилдаан зохион байгуулахраа шийдсэн бөгөөд энэ зардалд нийт 360000 төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс бүрэн зарцуулсан бөгөөд өсвөр үеийн болон ахмад үеийн бөхчүүдийн барилдаан зохион байгуулж явууллаа. 2009 онд Аймгийн баяр наадамд зургаан насны морьдын уралдаан болж 1200 орчим морь уралдаж давхардсан тоогоор 600 орчим унаач хүүхэд байна. 2009 оны Аймгийн баяр наадам болон Аймгийн аварга шалгаруулах " Сөрт" , "Уньт"-н тойромд цэц мэргээ сорин уралдаж нийт 300 гаруй шагачид оролцсон байна / Хэрэгжилт 90,0 хувь/	2008 эхлэн сондгой сарын барилдааныг уламжлан болгон , зохион байгуулан явуулан барилдааны зардалд нийт 240000 төгрөг, 2009 онд 360000 төгрөгийг тус тус зарцуулсан байна. Жил бүр өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах барилдааныг тогтмол зохион байгуулж байна. Энэ барилдаанд 14 сум сургуулийн 19 багийн 171 бөхчүүд 4 насны ангилалаар оролцлоо. АЗЗА ХХК-ийн 50 жилийн ойн барилдаан, 1000 цэргийн барилдаан, Атар газар эзэмшсэний 50 жилийн ойн барилдаан Ардчилсан холбооны ойн барилдаан зэргийг зохион байгуулав. Эдгээр барилдаанд нийт 1851 бөх оролцсон байна 2007 онд Бүрэг хангай суманд 3 сая төгрөгөөр нум сум авч өгөн 2009 онд Аймгийн баяр наадмаар насанд хүрэгчид залуучууд, өсвөр үеийн сурын харваан тэмцээн болж 50 гаруй тамирчид цэц мэргэнээ сорилоо. Жил бүр оролцогчдын тоо нэмэгдэж байна. / Хэрэгжилт 70,0 хувь/
17	Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай 2008.07.16 Дугаар 293	2009-2012 2013-2015 2016-2020	21	Аймагт гадаад хэлний сургалтыг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулахаар бэлэн болгоод байна. Булган сумын 1-р бүрэн дунд сургууль, "Эрдмийн өргөө" цогцолбор сургууль, Спортын дунд сургуулиудад тус бүр 21 компьютер бүхий англи хэлний лингафон кабинетуудыг байгуулж, Гурванбулаг суманд англи хэлний кабинет тохижуулаад байна. Бага ангийн 11 багшид англи хэл заах сургалтыг орон нутагт анх удаа зохион байгуулж, сургалт эрхлэх зөвшөөрөл олгоод байна. / Хэрэгжилт 100,0 хувь/	Жил бүр Англи хэлний мини олимпиадыг зохион байгуулж 250 гаруй багш, сурагчдыг оролцуулж хэвшлээ. Бүх сургуулиудад англи хэлний сурах бичиг, CD олгосон. Англи хэлний бүх багш нарыг 2-3 удаагийн сургалтад хамруулаад байна. Аймгийн ЗДТТ-ын ажилтнуудад англи хэлний сургалт явуулж эхлээд байна. / Хэрэгжилт 10,0 хувь/
18	Үндэсний хөтөлбөр батлах тухай 2008.08.13 Дугаар 316 /Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын багш бэлтгэх мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр/	2009-2015	46	Боловсрол соёлын газартай хамтран 14 сум, 1 тосгоны ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудад зөвлөн тусалж, 866 багшийг хамруулан 509 багшаас мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг төстээр авч, 64 зөвлөмжийг бичиж хүргүүлээ. 2009 онд давхардсан тоогоор 1400 багш мэдлэг боловсролоо дээшлүүлсний 854 нь орон нутагт, 265 нь бүсийн, 122 багш төвлөрсөн, 160 гаруй багш ажлын байранд тус тус мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагджээ. Мөн Малайз, Сингапур, БНСУ-д БСГ-ын мэргэжилтэн, ЕБС-ийн мэдээлэл зүйн багш тус бүр 1 хүний мэргэшлийг дээшлүүлсэн байна. МУБИС-тай хамтран Гурванбулаг суманд монгол хэл, гадаад хэлний багш нарын модуль сургалтыг зохион байгуулан, шилдэг илтгэлийн уралдаан явуулж, анх удаа МУБИС-ийн магистантурын элсэлтийн шалгалтыг зохиож 7 багшийг элсүүллээ. Мөн Боловсролын Үнэлгээний Төвтэй хамтран "Үндэсний шинжээч багшийн сургалт"-ыг аймагтаа зохион байгуулж, 21 багшийг үндэсний шинжээч болголоо. Түүнчлэн бага ангийн 11 багшид англи хэл заах сургалтыг орон нутагт анх удаа зохион байгуулж, сургалт эрхлэх зөвшөөрөл олгоод байна. Шинээр багшлах эрхийн үнэмлэх авахаар 75 багш материалаа ирүүлснийг хянан 65 багшийн материалыг БСШУЯ-нд явуулснаас 60 хүн багшлах эрхийн үнэмлэх авлаа. / Хэрэгжилт 100,0 хувь /	2008 онд төвлөрсөн, бүсийн, орон нутгийн, ажлын байран дээр мэргэжил дээшлүүлэх зэргээр давхардсан тоогоор 1000 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчидийг сургалтанд хамруулан, тэдэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Бүх сумдын сургууль, цэцэрлэгүүд дээр зөвлөн туслах групп 1-2 удаа ажиллуулж багш нарт зөвлөгөө өглөө. 1-3 жил ажиллаж байгаа залуу багш нарын зөвлөгөөнийг зохион байгуулж ахмад багш нарын туршлагыг судлуулах багш шавийн холбоо байгуулах ажил зохион байгуулсан. / Хэрэгжилт 25,0 хувь/
19	Хөтөлбөр батлах тухай 2009.01.14 Дугаар 10 /Монголын уламжлалт бий биелэгээ хөтөлбөр/	2009-2014	17	Үндэсний хөтөлбөрийг аймгийн соёлын байгууллагууд ард иргэдэд ойлголт бий болгосон. Уламжлалт бий биелгээний хуурцагийг бүх сумдад тараасан. / Хэрэгжилт 30,0 хувь/	2009 оноос эхэлж хэрэгжиж байгаа

20	Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөр батлах тухай 2009,09,30 Дугаар 303	2010-2014 2015-2019	58	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл бэлдэж байгаа бөгөөд 2010 оны 4 сард хуралдах аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. /Хэрэгжилт 10,0 хувь/	2010 оноос хэрэгжиж эхлэнэ
21	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай 2009,09,09 Дугаар 279 /Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр/	2010-2012 2013-2016	12	АНЭ-ийн мэс заслын эмчийг Гэмтлийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулан гэмтлийн эмч бэлтгэлээ.АНЭ 2009 онд мэс заслын тасаг ясны мэс заслын яаралтай тусламжийн иж бүрэн багаж хэрэгслээр хангагдсан.Гэмтлийн яаралтай тусламж үйлчилгээг хөдөө орон нутагт ойртуулах чиглэлээр Хишиг-Өндөр суманд эмнэлгийн шинэ барилга, Рашаант сумын эмнэлэгт өргөтгөл барих ажил эхэлсэн. Иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс Булган,Рашаант,Баяннуур сумдын төвд гудамж хороололд шөнийн гэрэлтүүлэг хийж, явган хүний зам тавигдсан,үерийн далаанд таних тэмдэг тавьж,гүүртэй болгосон нь осол гэмтлээс сэргийлэх аятай нөхцөл бүрдлээ. Зам тээврийн ослын улмаас нас барсан тохиолдол /100000 хүн тутамд / 23,7, Хүүхдийн осол гэмтлийн тохиолдол /10000 хүүхэд тутам/ 42,3 , Түлэгдэлт /10000 хүн тутамд/ 3,7 байна. /Хэрэгжилт 50,0 хувь/	2009 оноос эхэлж хэрэгжиж байгаа
23	Хөтөлбөр батлах тухай 2009,05,27 Дугаар 157 /Газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр/	2009-2014 2015-2020	24	Газар хөдлөлт бүргэх станцын мэдээллийг чанарын өндөр түвшинд тасралтгүй дамжуулан ажиллахад шаардагдах хөрөнгийг жил бүр сайдын багц болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд аймгийн газар хөдлөлтийн станцыг нүүлгэн шилжүүлж ажиллахаар боллоо. Газар хөдлөлтийн станц хэтэрхий хотын төвд байрласан өөрөөр хэлбэл үйлдвэрийн бүсэд байрлаж байгаа учир хэмжилт хийхэд хүндрэлтэй байлаа. орон нутагт хээрийн станцын харуул хамгаалалтын нэг ажилтны орон тоог шийдвэрлэж станцын болон төхөөрөмжийн сэлбэгийн жагсаалт гаргаж нөөцөлж байна. Орон нутгийн иргэд, Ерөнхий боловсролын сургуулиуд, байгууллагуудаар явж танин мэдэхүйн болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч сурталчилгааны материал тараан ажиллаа. /Хэрэгжилт 70,0 хувь/	2009 оноос эхэлж хэрэгжиж байгаа
Зургаа. Дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, байгаль орчин, газрын чиглэлээр					
1	Хөтөлбөр батлах тухай 1999,02,10 Дугаар 25 /Байгалийн гамшигийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр/	1999-2000 2001-2005 2006-2015 он	1	Цаг агаарын 7, 10 хоног, сарын урьдчилсан мэдээг мэргэжлийн байгуулагаас нь авч холбогдох газруудад хүргүүлж ажилласны дээр Хаврын хуурайшилттай үед хөдөлгөөнт экспедиц ажиллуулж, Сэлэнгэ суманд 2, тэшиг суманд 3, Хутаг-Өндөр суманд 1, нийт 6 удаа үүлэнд зориудаар нөлөөлөн бороо оруулж, ой хээрийн түймрийг унтраах, газар тариалангийн бүс нутагт чийг өгөх зэрэг арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. /Хэрэгжилт 100,0 хувь/	Цаг агаарын 7, 10 хоног, сарын урьдчилсан мэдээг зохиож, аймгийн онцгой комисс, Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар болон бүх сумдад тухай бүрт нь хүргүүлж, гамшиг ослын сэрэмжлүүлэг туха йбур сумдыг хангаж болзошгүй гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг цаг тухайд нь авч байна. /Хэрэгжилт 90,0 хувь/
2	Хөтөлбөр батлах тухай 1999,03,10 Дугаар 43 /Усны үндэсний хөтөлбөр/	2001-2005 2006-2010	1	Улсын төсвийн 12.0 сая төгрөгийн хөрөнгөөр 8, Тогтвортой амьжиргаа төслийн 3 сая 958.0 мянган хөрөнгөөр 5 булаг шандны эхийг тохижуулан хамгаалах ажил хийгдлээ. Аймгийн Залуучуудын Холбоотой хамтран сум бүрт 1 булаг, шандны эхийг тохижуулан хамгаалах ажил 60 хувьтай хийгдэж байна. Үүний зэрэгцээ орон нутгийн иргэдийг татан оролцуулж 30 гаруй булаг, шандны эхийг хамгаалах арга хэмжээг авлаа. Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Дашинчилэн суманд 0,24 га усан талбай бүхий 1 хөв цөөрөм, Рашаант суманд хуучин цөөрөм шанд байсан газарт тус бүр 0,02 га усан талбай бүхий 6 хөв цөөрөм байгуулсан. Улсын төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр шинээр нийт 40 худаг гарган, 21 худаг сэргээн засварласан байна. Мөн 12 гар худаг гаргажээ. Аймгийн нутаг дэвсгэрт орших томоохон нуур, гол мөрний сав газруудад хамгаалалтын бүс тогтоолгохоор санал боловсруулж, Усны газарт уламжлаад байна. Хэрэгжилт 100,0 хувь/	2000-2008 онд аймгийн хэмжээнд шинээр 368 худаг гарган, 72 худаг сэргээн засварласан байна. Мөн 157 гар худаг, 10 хөв цөөрөм байгуулан давхардсан тоогоор 120 орчим булаг шандны эхийг хашиж хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлжээ.Булаг шандны эхийг хашин хамгаалж, ус Цэвэр орчин-бодит ажил аяныг жил бүр зохион байгуулж гол, горхины гольдирул дагуух хог хаягдлыг бүх нийтээр цэвэрлэж жёны эхийг хамгаалах арга хэмжээг авч хэвшүүлээ. Үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтайгэрээ байгуулан гүйцэтгэлд нь хяналт тавьж, жил бүр аймгийн төсөвт 1,5-1,6 тэрбум төгрөгийг оруулж байна. Усны тоо бүртгэлийн ажлыг 2003, 2007 онуудад зохион байгуулж, эмчилгээ сувилгаанд өргөнөөр ашигладаг рашаануудыг судалгаа шинжилгээнд хамруулан найрлага, онцлог шинж чанарыг тодорхойлон сурталчилан ажиллаж байна.Усны үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор аймгийн усны дэд хөтөлбөрийг 2007 онд шинэчлэн гаргаж, жил бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Булган хотыг цэвэр усаар хангах цэвэр усны байгууламжийг 120,0 сая төгрөгийн өртөгтгээр барьж байгуулах ажил хийгдэж байна. Энэ төслийн хүрээнд 2 гүний худаг, 150 м3-ийн багтаамжтай 2 ус хадгалах резервуар, 1,7 км шугам хоолой тавих ажил хийгдээд байна. /Хэрэгжилт 90,0 хувь/

3	Хөтөлбөр батлах тухай 1999.03.24 Дугаар 50 /Хог хаягдлыг бууруулах тухай/	1999-2000 2001-2003 2003-2005 2005-2010 он	5	Булган сумын Хаягдал гялгар уут, хуванцар боловсруулах төслийг дэмжсэнээр тоног төхөөрөмжөө худалдан авч суурьлуулан цехийн барилгын дотоод засвар хийгдэж байна. Хагас боловсруулсан хог хаягдлыг Дархан-Уул аймагт нийлүүлэх гэрээ хийлээ. Аймгийн төвийн цэцэрлэгжүүлэлт, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, хог хаягдлын үйлчилгээг хариуцах 25 хүний бүрэлдэхүүнтэй хот тохижилт үйлчилгээний анги байгууллаа. "Эрүүл байгаль хөггүй орчин" аяныг зохион байгуулж, Булган хотын зүүн болон урд талаар урсдаг Ачуут, Зүүнтүрүүний голын голдрилыг 40 байгууллагын 1000-гаруй хүн оролцон цэвэрлэлээ. Булган сумын бүх байгууллага, айл өрхүүд орчин тойрноо цэвэрлэж хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлж хаягдлаа булшлах арга хэмжээг авлаа. Аяны хүрээнд аймгийн хэмжээнд 2651.5 тн хог хаягдлыг цэвэрлэж зайлуулсан байна. Баян-Агт сумын 20 га талбай бүхий хогийн цэгийг зөөж цэвэрлэн 2 га талбайд багтаан журамлан цэгцэллээ. Төв суурин газрын золбин нохой устгах ажлыг зарим суманд зохион байгуулж, 95 нохойг бүртгэлжүүлж, галзуугийн вакцинд хамруулан туулгалт өгснөөс гадна 86 нохойг устган хогийн цэгт булж устгалаа. Хэрэгжилт 100,0 хувь/	2006 онд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрээр Булган сумын гэр хороололын айл өрх, албан газруудаас гарах хог хаягдлын сарын хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож, албан байгууллагын 1 тэвш хогийг 10000 төгрөг, айл өрх бүрээс сард 600 төгрөгөөр тогтоож үйлчилснээр албан байгууллагын 954м3 хог хаягдлыг зайлуулж 360 айл өрхтэй хог хаягдлыг нь аничж зайлуулахгэрээ байгуулан ажиллав. Мөн Орхон, Бүрэхангай, Булган, Хишиг-Өндөр, Сайхан зэрэг сумдад сумын төвийн ойр орчмын газрыг цэвэрлэж нийт 8500- 10000 га газрын 5000 гаруй тн ахуйн хог хаягдал, малын сэг, зэмийг цэвэрлэн хогийн цэгт хаяж 16 голын голидрол цэвэрлэсэн байна. "Цэвэр-Орчин-2007" аяны хүрээнд байгаль орчноо хайрлан хамгаалах уламжлалт арга ухаан болон хууль, тогтоомжуудыг сурталчилан ажиллаж, 24 гол горхи, булаг шандны голидрол, 13426 га талбайн 6261 тн хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан "Цэвэр орчин-2008" аяныг зохион байгуулж, гол, горхи, булаг шандны голдрил, 5300 га талбайн 200 машин хогийг цэвэрлэх ажлыг хийлээ. Аймгийн хэмжээнд гол горхи булаг шанд, нуур цөөрмийн орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж усны нөөцийг хамгаалах болон жижиг гол, булаг шандны хамгаалалтын дүрмийг суртчилсан 12 ш самбарыг рашаан булгийн эхэнд байрлуулсан. Мөн аяны хүрээнд Булган-хотын шаардлага хангахгүй болсон 1400 м бохир усны шугам, цэвэрлэх байгууламжийг шинэчлэн ашиглалтанд өгсөн байна. Хэрэгжилт 90,0 хувь/
4	Хөтөлбөр батлах тухай 1999.04.21 Дугаар 64 /Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	1999-200 200-2005 2005-2010	8	Европын холбооноос хэрэгжиж байгаа "Малын эрүүл мэнд мал аж ахуйн зах зээл" төслийн хүрээнд 2009 оноос эхлэн хэрэгжүүлж МЭҮ анхан шатны нэгжүүдэд багаж тоног төхөөрөмж нийлүүлэгдлээ. Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, Мерси Кор байгууллагаас шувууны томуу өвчний халдвар хамгаалалын хувцас, бусад багаж тоноглол, оношлуур багажууд гэх мэт 33 нэрийн 10.4 сая, Улсын хөрөнгө оруулалтаар 24 нэр төрлийн 12.8 сая төгрөгний оношлуур нийлүүлэгдсэн буюу нийт 24.9 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгджээ. ХЯБХХН-ээс 454.0 мянган төгрөгний микроскоп, 543 мянган төгрөгний тоног төхөөрөмж авч мал эмнэлгийн оношлогооны үйл ажиллагаа сайжирлаа. Одоогийн байдлаар Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах бүх төрлийн вакциныг татан авч сумдад хувиарлан технологит хугацаанд нь хийж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр адууны цус багадах өвчин ям, сүрье, хээл хаялтанд нөлөөх өвчин, бруцеллээс өвчний ээлжит шинжилгээг зохион байгуулдаг энэ жил 5сарын 20-аас 6 сарын 20, 8 сарын 20-оос 9 сарын 20-ны хооронд дээрхи өвчнийг тандах ээлжит шинжилгэг зохион байгуулсан. Хэрэгжилт 90.0 хувь/	Аймгийн Засаг даргын 1999 оны 07 сарын 17 өдрийн 263-р захирамжаар "Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр"-ийг баталж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцдогоос гадна жил бүрийн нэгдүгээр сард Засаг даргын зөвлөлд танилцуулж, хөтөлбөрийн санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгаж байхаар төлөвлөн ажиллаж байна. Уг хөтөлбөрийг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2 үе шаттайгаар зохион байгуулж /2000-2005, 2005-2010 он хүртэл/ байна. жил бүр малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах 15 төрлийн вакциныг татан авч сумдад хувиарлан технологит хугацаанд нь гүйцэтгүүлээ. Халдварт болон паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд жил төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байна. адууны халдварт цус багадах өвчний шинэжилгээ хийж өвчтэй гарсан малыг нядалж устгалаа. Хэрэгжилт 90.0 хувь/
5	Хөтөлбөр батлах тухай 1999.09.12 Дугаар 147 /Сум суурин газрын дулаан хангамжийн үндэсний хөтөлбөр	1999-2000 2001-2005 2006-2010	2	" Сум суурин газрын дулаан хангамжийг сайжруулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн сумдын халаалтын системийг шинэчлэх, өргөтгөх, түлш бага хэрэглэдэг найдвартай зуухаар хангах зорилт тавьж, улсын төсвийн болон олон улсын төсөв хөтөлбөрийн 500 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Булган, Хутаг-Өндөр сумын төвлөрсөн халаалтын зуух, Баян-Агт, Бүрэгхангай, Баяннуур, Тэшиг сумдын сургууль, Хялганат тосгон, Дашинчилэн, Орхон сумдын соёлын төв, Тэшиг сумын цэцэрлэг, дотуур байр зэрэг газруудад шинээр халаалтын тогоо суурилууллаа. / Хэрэгжилт 100,0 хувь /	Сумдын халаалтын системийг шинэчлэх, өргөтгөх, түлш бага хэрэглэдэг найдвартай зуухаар хангах зорилт тавьж, улс, орон нутгийн төсвийн болон олон улсын төсөл хөтөлбөрийн 1850 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 17 суманд төр, төсвийн байгууллагуудын 70 гаруй халаалтын тогоо шинэчлэн солилоо. / Хэрэгжилт 70,0 хувь /
6	Хөтөлбөр батлах тухай 1999.10.06 Дугаар 158 /100000 нарны гэр үндэсний хөтөлбөр	2000-2010	4	"Буман нарны гэрэл " хөтөлбөрийг хэрэгжүүлэн аймгийн хэмжээнд 7293 малчин өрхтэйгээс 2257 өрх нь 2009 онд нарны цахилгаан үүсгүүрийг зах зээлээс худалдан авч, нийт 5217 өрх нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй боллоо. Үүний үр дүнд хөдөөгийн малчин өрхийн 70 хувь нь сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан нь өнгөрсөн оноос 25 хувиар өссөн байна. / 2009 онд манай аймаг уг хөтөлбөрт хамрагдаагүй болно. /	"Буман нарны гэрэл " хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 2003-2004 онд 1010, 2008 онд 1967, нийт 2977 малчин өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангасан /Хэрэгжилт 70,0 хувь /

7	Хөтөлбөр батлах тухай 2002.07.08 Дугаар 146 /Чанарын болон байгаль орчны удирдлагыг дэмжих үндэсний хөтөлбөр	2002-2006 2007-2011 2012-2016	4	Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны мэдээллийн сүлжээг боловсронгуй болгож хөгжүүлэх зорилтын хүрээнд мэдээллийн санг үндэсний 1528, олон улсын 560, байгууллагын 14, нийт 2102 стандартаар баяжууллаа. Цэвэр үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр "Алтан намар" үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 5 номинациар шалгаруулалт явуулж "Оны шилдэг бүтээгдэхүүн"-ээр Хутаг-Өндөр сумын "Гурван борхууд"ХХК -ний "Үсэлсэн халтар арвай", "Хэрэглэгчийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн"-ээр Булган сумын Баяжигч талхны цөхийн "Гурилан бүтээгдэхүүн", "Экологийн цэвэр бүтээгдэхүүн"-ээр Тэшиг сумын "Тагар" сонгино, "Импортыг орлох бүтээгдэхүүн"-ээр Булган сумын "Булган ундрага"ХХК-ний "Чацарганы жүүс", "Шилдэг сав баглаа боодолтой бүтээгдэхүүн"-ээр Сэлэнгэ сумын "Сайхан харзтай"ХХК-ний "Шим бог будаа" шалгарлаа. 2009 онд Усны тоолуур баталгаажуулах эталон тоног төхөөрөмж авч улсын шалгагчийг бэлтгэж үйл ажиллагаа явуулж байна. Хүндийн хэмжлийн 2 улсын шалгагч сургалтанд хамрагдаж эрхээ сунгуулсан ба архи булаг шанд, нуур цөөрмийн орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж усны нөөцийг хамгаалах болон жижиг гол, булаг шандны хамгаалалтын д	Стандарт сан мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох зорилт тавьж ажилласанаар аймгийн стандарт мэдээллийн санд үндэсний болон олон улсын, компаны нийт 2102 стандарт архивлаж хэрэглэгчдэд нээлттэй үйлчилж байна. Цэвэр үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр аймгийн "Экологийн цэвэр бүтээгдэхүүн" дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, оны шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, бүс улсын хэмжээний үзэсгэлэн худалдаануудад оролцуулж брэнд бүтээгдэхүүнүүдийг баталгаажуулах ажлуудыг түлхүү зохион байгуулаа. Орон нутгийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжиж хүүгийн хөнгөлттэй зээл болон төсөл хөтөлбөрүүдэд хамрагдахад дэмжлэг үзүүлсэнээр байна. Хэрэгжилт -100,0 хувь
8	Хөтөлбөр батлах тухай 2003.06.24 Дугаар 160 /Эрчимжсэн мал аж ахун хөгжлийг дэмжих хөтөлбөр	2003-2008 2009-2015	3	Мянганы хөгжлийн сорилтын сангаас хэрэгжүүлж байгаа "Хот орчмын бэлчээрийн төслийн хүрээнд Хангал, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Орхон, Сэлэнгэ сумдад 56 эрчимжсэн аж ахуй байгуулахаар өрхөө сонгоод байна. Энэ чиглэлийн аж ахуй нэгжүүдийг сонгон шалгаруулж аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас хөнгөлөлтэй зээл олгож байна. Аймгийн хэмжээнд Сэлэнгэ, Хангал, Бугат, Булган сумдад шинээр 7 үхрийн болон гахайн фермерийн аж ахуй байгуулагдсан байна. ХХААХУЯ, НХХЯ-ны хамтран хэрэгжүүлж байгаа "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд Гурванбулаг, Могод, Хутаг-Өндөр сумдаас 30 малчин өрхийг сонголоо. Мөн ДЗОУБ-аас тус аймагт хэрэгжиж байгаа орлого багатай малчин өрхүүдийг сонгон малжуулах төсөлд Булган сумаас 21 өрх, Сэлэнгэ, Хангал, Орхон, Хишиг-Өндөр сумдаас 50 гаруй өрх хамрагдаж, Дашинчилэн суманд үхрийн фермерийн аж ахуй байгуулагдлаа. /Хэрэгжилт 90,0 хувь/	аймгийн хэмжээнд хөтөлбөр хэрэгжиж эхлэсэнээс хойш 10 сум эрчимжсэн аргаар үхэр хонины мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх дэд хөтөлбөрт хамрагдаж 34 эрчимжсэн чиглэлийн аж ахуй байгуулагдсан байна. Мянганы хөгжлийн сорилтын сангаас хэрэгжүүлж байгаа "Хот орчмын бэлчээрийн төсөлөөр 56 эрчимжсэн аж ахуй байгуулахаар бэлтгэж байна. аймгийн ЖДҮ-ийг дэмжих сангаас энэ чиглэлийн 14 аж ахуйн нэгжид хөнгөлөлтэй зээл олгож дэмлэг үзүүлээ. мөн фермерийн аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж иргэдэд газрыг төсөл сонгон шалгаруулах журмаар олгож татвар, хүүгийн хөнгөлөлт үзүүлж байна. 2009 оны байдлаар газар тариалан мал аж ахуй хосолсон загвар 7 аж ахуйтай болсон. Хэрэгжилт 60,0 хувь/
9	Хөтөлбөр батлах тухай 2004.08.05 Дугаар 169 /Өрхийн орлогыг нэмэгдүүлэх "ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөр/	2-р үе 2005-2012 он		" Ногоон хувьсгал хөтөлбөрөөс 40.0 кг хүнсний ногооны үр хувиарласныг хуваарь гарган сумдад олголоо."Агропарк" төсөл"-ийг нийт сумдад хэрэгжүүлсний үр дүнд аймгийн хэмжээгээр 505.0 тн багтаамжтай 18 зоорь баригдаж, хамгаалалттай хөрсний тариалалт өмнөх жилийнхээс 1920 м/ кв-аар нэмэгдэж, өрхийн үйлдвэрлэлийн зориулалтын бага оврын трактор агрегат бүх сумдад олгогдож үйл ажиллагаа нь жигдэрлээ. мөн Өрхийн тариалан эрхлэгчидэд хамгаалагдсан хөрсний тариалалтын талаар сургалт хийлээ. Шинэ техник технологийн холбогдолтой 100 гаруй гарын авлагыг бэлтгэж өрхийн тариалан эрхлэгчдэд хүргүүлээ / Хэрэгжилт 100,0 хувь/	хөтөлбөр хэрэгжиж эхлэсэнээс хойш суурин газрын 7200 айл өрх төмс хүнсний ногоо тариалж байна. мөн хойд бүсийн сумд Герман , Голланд улсын Импала , Витара , Санте сортын 30 гаруй тн төмсний үрийг 12 сумын 24 иргэн 14 га-д тариалж өндөр ургац хураан авч , эдгээр сортын үрийг бүх сумдад, үржүүлэх ажлыг зохион байгуулж эхэлээ. ногоон хувьсгал хөтөлбөртэй уялдуулан "Булган- Зоорь" хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд 4.8 мянган тн-ын багтаамжтай 729 зоорь шинээр баригдаж, төв суурингийн айл өрхийн 50 гаруй % нь зоорьтой болсон байна. / Хэрэгжилт 60,0 хувь/
10	Үндэсний хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2005.03.09 Дугаар 44 "Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр"	2005-2015 2015-2025 2025-2035	6	2009 онд Дашинчилэн суманд "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх туслах зурвасыг 10 га талбайд хийлээ. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг 959.4 га талбайд хаврын тарилтыг 75-89%-ийн амьдралттай хийж гүйцэтгээд байна. 2010 оны ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлын бэлтгэлд аж ахуйн нэгж байгууллагууд нь нийт 945000 ширхэг тарьц, 35000 ширхэг суулгац, 25 кг үрийг бэлтгэсэн байна. /Хэрэгжилт 100,0 хувь/	2005 онд Баяннуур суманд 400 м өргөнтэй 500 м урттай туслах зурвас байгуулан 7500 ширхэг мод, бут сөөг тарьж арчилгаа тордолт хийн ажиллаж байна. Энэ ажилд Улиас 3000, хайлаас 2500, чацаргана 3000 ширхэгийг нийт 24 га талбайд тариллаа. 2006 онд мөн 24 га-д ойн туслах зурвас байгуулав. Намрын тооллогоор амьдралт 70 хувьтай байсан тул нөхөн тарилтаар 2500 ширхэг улиасны 2 настай суулгац нэмж тарисан. Геоэкологийн хүрээлэнгийн ойн үрийн лабораторитой хамтран шинэсний сонгомол үр бэлтгэх нөөц талбайн судалгааг Орхон, Хутаг-Өндөр, Бугат сумдад хийж нийт 3000 га талбайг сонгон тусгаарласан цаашид уг талбайгаас үр бэлтгэх боломжтой болсон. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж Баяннуур суманд 10 га газар ойн зурвас байгуулан цөлжилтийг багасгах, элсний нүүдлээс хамгаалах арга хэмжээ авч цагаан, хүрэн бургас, агч, харгана, шар хуайс, хайлаас, гүйлс, улиасыг нийт 39000 ширхэгийг тариалсан. Дашинчилэн сумын албан газар ,айл өрх элсний нүүдлээс хамгаалах зорилгоор сумын төвд 1678 ширхэг мод тарьсан бөгөөд бэлчээр талхлагдан цөлжилт явагдахыг багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, 2 га бэлчээрийг хашиж, 20000 га бэлчээрийг биотехнологийн хамгаалалтын арга хэмжээ авсан байна. Гурванбулаг сумын төвийн хойд хэсгээр 2 бичил ойн зурвас байгуулж элсний нүүлтээс хамгаалах, ажил зохион байгуулав. /Хэрэгжилт 25,0 хувь/

11	Хөтөлбөр батлах тухай 2005,04,01 Дугаар 64 "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"	2005-2006 2007-2008 2009-2010	11	Үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийг хүүгийн хөнгөлттэй зээлээр дэмжиж санхүүгийн чадавхыг сайжруулахаар улсын төсвөөс 565,0 сая, орон нутгийн төсвөөс 130.0 сая, арилжааны банк 208.5 сая төгрөг нийт 903.5 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр төвлөрүүлж ЖДҮДС-д ирүүлсэн 170 гаруй төслүүдийг хэлэлцэж хүнсний үйлдвэрийн 21, хөдөө аж ахуйн 18, боловсруулах болон хөнгөн үйлдвэрийн 28, ахуйн үйлчилгээний 12, Худалдаа үйлчилгээний 8 нийт 87 төсөлд хөнгөлттэй зээлийг 100 хувь олголоо. /Хэрэгжилт -100,0 хувь/	2005 онд "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан"-г 10,0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэртэй байгуулж жил бүрийн төсөвт сангийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээр тусгаж орон нутгийн төсвөөс нийт 130,0 сая төгрөгийн хөрөнгө хувиарлаж жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг хүүгийн хөнгөлттэй зээлээр дэмжиж ажиллаа. 2009 онд үйлдвэржүүлэлтийг дэмжих бодлогын үр дүнд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд улсын болон орон нутгийн төсөв, арилжааны банкнаас нийт 903,5 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр төвлөрүүлж үйлдвэрлэл эрхлэгчдийг хүүгийн хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. /Хэрэгжилт - 70,0 хувь /
12	Хөтөлбөр батлах тухай 2005,06,22 Дугаар 138 "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөр	2005-2008 2009-2012		Орон нутгийнхаа түүхий эд, нөөцөд түшээглэсэн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, зээл хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, борлуулалтын сүлжээ бий болгоход дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг зонхилж хэрэгжүүллээ. 10 сумын брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, зориулалтын ажлын байранд ажил үйлчилгээгээ явуулах нөхцөл боломжыг бүрдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх зорилгоор 150,0 гаруй сая төгрөгийн хөнгөлттэй зээл олголоо. Энэ онд Намрын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээнд зээл авсан аж ахуйн нэгж иргэд брэнд бүтээгдэхүүнээрээ оролцож Могод сумын айраг "Үнэмлэхүй шилдэг бүтээгдэхүүн" 3 жилийн хугацаатай батламж, Цөм сүргийн үржлийн төвийн нарийн нарийвтар ноост Хангай үүлдрийн хонь "Шилмэл мал-2009" Алтан медаль хүртэж, Сайхан сум зохион байгуулалт сайтай оролцсон байгууллага "Булган Ундарга" ХХК-ны жимс, жимсгэнэ бүтээгдэхүүн Хангайн бүсийн 2009 оны "Экологийн цэвэр бүтээгдэхүүн"-ээр шалгарлаа. Хэрэгжилт -90,0 хувь /	2005 оноос эхлэн орон нутгийнхаа иргэдийн бахархал болохуйц "брэнд" бүтээгдэхүүнтэй болох зорилт дэвшүүлж "Нэг сум-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөн өрнүүлсэнээр жилээс жилд брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдэж нэр хүнд нь өсч тодорхой үр дүнгээ өгч байна. 2005-2008 онуудад брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг үйлдвэрлэл, хоршоо, нөхөрлөл, бүлэг хамтын хэлбэрт оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласанаар аж ахуйн нэгж болж үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн хариуцлага дээшиллээ.Сумдын брэнд бүтээгдэхүүнүүд 2005-2009 онуудад аймаг, бүс, улсын хэмжээнд зохион байгуулагдсан шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах арга хэмжээнүүдээс "Экологийн цэвэр Брэнд бүтээгдэхүүн"-ий шагнал хүртэж баталгаажигдлаа. Тухайлбал "Экологийн цэвэр бүтээгдэхүүн"-ээр Сайхан, Могод, Хишиг- Өндөр сумдын айраг, Хангал сумын "Зөгийн бал", Тэшиг сумын "Цөцийн тос", Баяннуур сумын "Чацаргана", Сэлэнгэ сумын "Бог будаа", Орхон, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Бүрэгхангай, Бугат, Булган сумдын төмс, хүнсний ногоо болон Орхон сумын "Орхон мандал" ХХК-ны үйлдвэрлэсэн 1, 2 дугаар гурил, мал аж ахуйн салбарт гойд чанартай, шилмэл үүлдрийн мал болох Цөм сүргийн үржлийн албаны "Хангай үүлдрийн хонь", "Сэлэнгэ үүлдрийн үхэр" нь Намрын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээний "Шилмэл мал 2005-2009" арга хэмжээнүүдээс жил дараалан алт, мөнгө, хүрэл медалиуд хүртэж байсан. Хэрэгжилт - 70,0 хувь
13	Хөтөлбөр батлах тухай 2006,04,26 Дугаар 93 "Малын чанар сайжруулах хөтөлбөр"	2006-2015 он 2006-2008 2008-2012 2012-2015		малын чанар сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлд баримлах бодлого боловсруулан ажиллаж байна. Хойд бүсийн сумдын үхэр сүрэгт Сэлэнгэ үүлдрийн хээлтүүлэгчийг ашиглах аймгийн Засаг даргын 2009 оны 152 тоот захирамж гаргалаа. монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусган ажиллаж байна. Мянганы хөгжлийн сорилтын сангаас хэрэгжүүлж байгаа "Хот орчмын бэлчээрийн төслийн хүрээнд Хангал, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Орхон, Сэлэнгэ сумдад байгуулах эрчимжсэн аж ахуй сонгон шалгарууллаа. Энэ онд шинээр байгуулагдсан үржлийн нэгжүүдийг түшиглэн бод малын зохиомол хээлтүүлгийн 8 цэг ажиллуулаж, 386 үнээнд ичээл үр суулгаж, хээлтүүлэг хийсэн байна. Хэрэгжилт 90,0 хувь/	Малын чанар үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Булган-Цөм сүргийн үржлийн аж ахуйд "Сэлэнгэ" үүлдрийн бух, Барга омгийн хуц, Баруун Монголын ууцан сүүлт охин төлөг өсгөн бойжуулж байна. Үхэр сүргийн үндсэн сайжруулагчаар Сэлэнгэ үүлдрийн үхрийг, адуун сүргийг Хэнтий, Сүхбаатараас угшил сайтай азарган үрээгээр, хонийг Барга, Дархадын ууцан сүүлт, ямааг Баяндалгэрийн улаан, Эрчмийн хар ухныг ашиглаж үржлийн ажил явуулсан байна. ХЯБХН -тэй байгуулсан тогтвортой байдлыг хангах гэрээний дагуу цөм сүргийн аж ахуйг бэхжүүлэх зорилгоор "Булган-ЦСҮАА"-д 3,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, мал жинлэх механик пүү, ноос, ноолуурын гарц тодорхойлох электрон жин олгосны дээр Бугат, Орхон, Хангал, Хутаг—Өндөр сумдад зохиомол хээлтүүлгийн нэгж байгуулан эдгээр нэгжүүдэд 4,8 сая төгрөгний багаж төхөөрөмж нийлүүлж, үржлийн ажил, үйлчилгээ явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо азарганд 12, буханд 29, хуцанд 65, уханд 67 ноогдож байгаа нь 2006 онтой харьцуулахад 40 хувь өссөн байна. мөн аймгийн нийт мал сүрэгт өндөр ашиг шимтэй малын тоо 7 хувьд хүрсэн. / Хэрэгжилт 60,0 хувь/
14	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр батлах тухай 2006,05,03 Дугаар 99	2007-2010 2011-2020	6	Монгол улсын "Зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай" хуулийг олшруулах сумдад хүргүүлж, удаан задардаг нийлэг хальсан уутыг худалдаа үйлчилгээнд баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг хориглож, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах талаар үүрэг чиглэл өглөө. Удаан задардаг органик бохирдуулагчийн хэмжээг багасгах зорилгоор Булган сумын дахин боловсруулах үйлдвэр байгуулах туслийг дэмжиж Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 10.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосноор тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулаад байна. /Хэрэгжилт 70,0 хувь/	Химийн хорт бодисын тооллогыг Монгол Улсын Их Сургуулийн Биологийн Тэнхимийн сургуулийн 3 дугаар курсын 4 оюутнуудтай хамтран, мөн Сумдын Байгаль орчны Улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран химийн хорт бодисын тооллого хийлээ. Байгаль хамгаалах нэгдсэн холбоотой хамтран 20 сая төгрөгийн төсөл боловсруулж, Хятад улсаас хог хаягдлыг боловсруулах дунд оврын үйлдвэр оруулж ирэх талаар судалж байна. Энэ төсөл хэрэгжсэнээр аймгийн төвийн хуванцар болон нийлэг материалан хог хаягдлыг дахин боловсруулах замаар ажлын байр нэмэгдэх нөхцөл бүрдэх юм. / Хэрэгжилт 50,0 хувь/

15	Хөтөлбөр батлах тухай 2006,06,21 Дугаар 140 /Шингэрүүлсэн шатдаг хий хөтөлбөр/	2006-2010	5	Булган хотод 25-200 шоометр хий цэнэглэх хүчин чадалтай цэгийг барьж байгуулах ажлын судалгааг хийж байна. /Хэрэгжилт 30,0 хувь/	Иргэдийн өдөр тутмын хэрэгцээг хангах зорилгоор шингэрүүлсэн шатдаг хийн үйлчилгээ үзүүлэх 2 цэг байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан боловч, орон нутгийн онцлог, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ багатай зэргээс шалтгаалан татан буугдсан байна. /Хэрэгжилт 10,0 хувь/
16	Хөтөлбөр батлах тухай 2006,10,11 Дугаар 246 /Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр/	2006-2010 2010-2015	3	2009 онд төвлөрсөн бохир усны шугам сүлжээнд холбогдоогүй байсан Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, 12 жилийн 1 дүгээр сургууль, бага сургуулийг шинээр холбож, ариун цэврийн шаардлага хангасан нөхцөлд амьдарч байгаа хүмүүсийн тоог 2500 хүнээр нэмэгдүүллээ. /Хэрэгжилт 100,0 хувь /	2008 оноос эхлэн Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр "Орон нутгийн хоёрдогч хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах төсөл" хэрэгжиж Булган сумын 1340 метр газарт бохир ус зайлуулах хоолой шинээр угсарч, бохирын 29 худаг шинээр барьж, улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна. Үүний үр дүнд 60 орчим албан байгууллага, аж ахуйн нэгж, 300 гаруй айл өрхийн 17 мянган куб метр бохир усыг шахан зайлуулж байна. / Хэрэгжилт 50,0 хувь/
17	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай 2006,12,20 Дугаар 309 "Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах үндэсний хөтөлбөр"	2007-2008 2008-2010	5	Аймгийн хэмжээнд одоогоор олборлолтын үйл ажиллагаа явуулж буй төмрийн хүдэр олборлох 1, алт олборлох 8, нүүрс олборлох 2 нийт 11 уурхайд үйл ажиллагаа явуулж байна. Ашигт малтмал олборлогч 6 аж ахуйн нэгж нийт 143,7 га-д техникийн нөхөн сэргээлт хийж аймгийн ажлын хэсэгт хүлээлгэн өглөө. Мөн Шижир-Алт ХХК 31,3 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг олон наст ургамал тариалан хийсэн нь 80-аад хувьтай ургаж байгаа бөгөөд энэ байгалийн олон зүйлийн ургамал даган ургах таатай нөхцлийг бүрдүүлж байна. Хэрэгжилт 90,0 хувь/	2007 онд "Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах аймгийн дэд хөтөлбөр"-тэй болж, аймгийн Засаг даргын 2007 оны 220 дугаар захирамжаар уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. 2007 онд Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрээс алт олборлогч "Шижир-Алт" ХХК техникийн нөхөн сэргээлтийг 58 га талбайд, "Төсөлч" ХХК техникийн нөхөн сэргээлтийг 1 га талбайд, мөн биологийн нөхөн сэргээлт 1 га талбайд хийж буйлс, чацаргана, хайлаас зэрэг мод бут тарьсан. 2008 онд Шижир алт ХХК-ний нөхөн сэргээлтийг хүлээн авлаа. Тус компани нь 100 га талбайд биологийн, 57 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн бөгөөд биологийн нөхөн сэргээлтэнд царгас, өрхөг, сибир өлөн зэрэг олон наст ургамал тарьсан нь 80 хувьтай сайн ургаж байна. Мөн Монполимет ХХК-ний 27 га, Есөн эрдэнэ ундрага ХХК-ний 5,8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийснийг ажлын хэсэг хүлээн авлаа. БОЯ, УМХГ, АМГТХЭГ-уудтай хамтран Тэшиг сумын 3-р багийн Ногоон толгойд 0,04 га талбай бүхий мөнгөн усаар бохирдсон 120 м3 шлам ул хөрсийг зохих журмын дагуу тээвэрлэн сонгосон цэгт булшлах, нөхөн сэргээх ажлыг зохион байгууллаа. Шлам, ул хөрсийг булшилсан талбайг Тэшиг сумын холбогдох албан тушаалтнуудад хүлээлгэн өгсөн болно. /Хэрэгжилт 50,0 хувь/
18	Хөтөлбөр батлах тухай 2007,11,07 Дугаар 283 /Малын тэжээл үндэсний хөтөлбөр/	2008-2011 2012-2015	4	Малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ-наас 8 тн овьёс, 6тн хөх тарианы үр хувиарласаныг 11 аж ахуйн нэгж, 3 иргэнд гэрээгээр олгож, 106 га-д тариалал хийж 322 тн ургац хурааж, 2958 тн ногоон тэжээл бэлтгэв. Сумд хадлан бэлтгэх талбай, болон бэлчээрийг хувиартай ашиглах малын хөлөөс чөлөөлөх арга хэмжээг зохион байгууллаа. аймгийн хэмжээнд 80,3 мянган тн хадлан бэлтгэлээ. Хадлан бэлтгэх бололцоогүй урд бүсийн сумдыг малчдаас захилага авч нэгтгэх, сумын мал хамгаалах санд өвс тэжээл нөөцлөх талаар мал аж ахуйн өвчлөлтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөн тусгаж сумдын Засаг дарга нарт даалгасан / Хэрэгжилт 90,0 хувь/	НҮБ-аас хэрэгжүүлж байгаа "Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, техник хамтын ажиллагааны төсөл"-д Хангал сумын "Сүмийн нуга"ХХК, Сэлэнгэ сум "Ургацын түрүү" хоршоо 4 малчны бүлгийг хамрагдсан. 2009 онд малын тэжээл үйлдвэрлэхээр төсөл бэлтгэсэн 2 иргэнд ЖДҮ дэмжих сангаас хөнгөлөтэй зээл олгосон. аймгийн хэмжээнд гурил үйлдвэрлэж байгаа томоохон хэмжээний 5 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Булган ГТХК 2009 оноос эхлэн багсармал тэжээл үйлдвэрлэж байна. Хонгор агро, Өрмөгтий, Ингэттолгой, Орхон мандал Хас тав зэрэг аж ахуйн нэгжүүд хивэг үйлдвэрлэж байна. /Хэрэгжилт 50 хувь/

19	Хөтөлбөр батлах тухай 2008,02,27 Дугаар 70 /"Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр/	2008-2010	5	<p>2009 онд аймгийн хэмжээгээр 93 аж ахуйн нэгж, 30 гаруй иргэн 27250 га-д үр тариа тариалж 48057 тн , 876 га-д төмс, тариалж 8113 тн, 300 га-д хүнсний ногоо тариалж 2932 тн ургац, буюу үр тариа нэгжээс 18.3 цн хураан авч сүүлийн 10 жилд гараагүй амжилт гаргав. 2009 онд 30200 га-д уринш бэлтгэж 2007 оныхоос 14893 га-гаар ахиу бөгөөд , эргэлтэнд орж байгаа талбай 13.5 мянган га-аар нэмэгдэв. Газар тариалангийн үйлдвэрлэлээс 20 гаруй тэрбум төгрөгийн орлоготой ажиллав. Газар тариалангийн жижиг аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэх дундын техникийн паркыг Хутаг-Өндөр, Сэлэнгэ суманд байгуулж, өрхийн тариалан эрхлэгчдэд үйлчлэх журам боловсруулан мөрдөж уринш бэлтгэх болон ургац тээвэрлэх үйлчилгээ хийв. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж энэ онд 65 ш бага оврын тракторыг агрегатын хамт хөнгөлөлттэй үнээр олгов. Монгол улсын Засгийн газрын 136-р тогтоолоор батлагдсан , сум бүрт 9,4 сая төгрөгний " Агро парк " байгуулах ажлыг 16 суманд бага оврын трактор агрегат , 120 м.квт талбай бүхий нийлэг хальсан хүлэмж , 30 тн-ын зоорь барих хөрөнгийг олгож , гүйцэтгэлд нь хяналт тавин , ажиллаж байна. Хаврын тариалалтанд зориулж, өнгөрсөн онд 35 аж ахуйн нэгж, 28 иргэнд 1200 тн энэ онд 61 аж ахуйн нэгж, 23 иргэнд 1000 гаруй тн буудайг хөнгөлөлттэй үнээр олгов. "Булган- Зоорь" хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд 4.8 мянган тн-ын багтаамжтай 729 зоорь шинээр баригдаж, төв суурингийн айл өрхийн 50 гаруй хувь нь зоорьтой болсон байна. " Монгол төмс " хөтөлбөрийн хүрээнд Герман , Голланд улсын Имвала , Витара , Санте сортын 30 гаруй тн төмсний үрийг 12 сумын 24 иргэн 14 га-д тариалж өндөр ургац хураан авч , эдгээр сортын үрийг бүх сумдаа үржүүлэх ажлыг зохион байгуулж байна. /Хэрэгжилт 100,0 хувь/</p>	<p>"Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг УГТСЭШХ, "Ургацын далай холбоотой хамтран зохион байгуулсан. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ИТХ-ын тэргүүлэгчдийн 4-р сарын 02 ны 67-р тогтоолоор батлуулан мөрдөж ажиллаа. "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн зөвлөлийг Засаг даргаар ахлуулан 18 хүний бүрэлдхүүнтэй байгуулсан. Засгийн газраас газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд 2.0 миллиард төгрөгний итгэлийн зээл , уринш бэлтгэхэд зориулж 1000.0 гаруй сая, хаврын тариалалтанд зориулж 4.2 мян.тн буюу 5.5 милл төгрөгний шатахууныг 115 аж ахуйн нэгж, иргэдэд олгосны үр дүнд техникийн шинэчлэлт , хаврын тариалалт , уринш боловсруулалт , хураан авсан ургацын хэмжээ нилээд хэмжээгээр нэмэгдлээ. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт эргэлтийн талбайн 76 % буюу 50.0 гаруй мянган га - г эргэлтэнд оруулахаар төлөвлөн хэрэгжүүлж, Хөтөлбөрийн механикжуулагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд гадаад дотоодын болон орон нутгийн сургалтанд 869 тариаланчид хамрагдсан байна. Тариалан эрхлэлтийг дэмжих сан байгуулах ажлыг зохион байгуулж, дүрэм, журмыг батлан 3 сумын 5 иргэнд тариалангийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэв. Жимс жимсгэний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор " Жимс жимсгэнэ" хөтөлбөр хэрэгжүүлж, 8 суманд 137.8 га-д жимс жимсгэнэ тариалж байна. Мөн ХХААЯ-ны жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжих төсөлд 2 аж ахуйн нэгж, иргэний төсөл хамрагдан 25 сая төгрөгний дэмжлэг авлаа. /Хэрэгжилт 90,0 хувь/</p>
20	Хөтөлбөр батлах тухай 2008,03,05 Дугаар 84 /Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр/	2008-2010 2011-2015	23	<p>Булган хотын төвлөрсөн усан хангамжын нэгдсэн системийг шинээр барьж, гэр хорооллын нэг усан санг холбоод байна. Ингэснээр аймгийн төвийн 78 аж ахуйн нэгж, 468 айл өрхийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн цэвэр усаар хангаж байна. Аймгийн хэмжээнд нийт 16 сумтай бөгөөд сум бүрт гүний худгаас хүн амын ундны усыг хангаж байна. Урд сумдаас Дашинчилэн, Гурванбулаг, Баяннуур сумдын худагт ус зөөлөрүүлэх төхөөрөмж суурилуулсан. Малчдын ундны усан хангамж жил бүр 40 гүний худаг гараж эрүүл ахуйн шаардлага хангасан барилгатай баригдаж байна. Чех улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд 30 цэгт газрын доорхи усны эрэл хайгуул хийгдсэн. /Хэрэгжилт 70,0 хувь/</p>	энэ талаар ажил хийгдээгүй өмнөх онуудад
21	Хөтөлбөр батлах тухай 2008,07,09 Дугаар 288 /Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр/	2008-2016	18	<p>"Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил"-д ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж аймгийн төвд ахуйн үйлчилгээний төв, сумдад цэг бий болгох зорилт дэвшүүлж эхний ээлжинд Орхон сумын ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэгийн барилгын засвар үйлчилгээг "Тогтвортой амьжиргаа II" төслөөр санхүүжүүлж, ахуйн үйлчилгээний үйл ажиллагааг өргөжүүлэх 13 бизнес төсөлд 80,0 гаруй сая төгрөгний дэмжлэг үзүүлж 1 төсөлд -30,0 сая зээлийн эрх олголоо. Аймгийнхаа ахуй үйлчилгээний салбарт ажиллагсадыг ХХААХҮЯ, Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбоо, Орхон аймгийн Засаг даргын тамгын газраас хамтран зохион байгуулсан "Ахуйн үйлчилгээний жишиг төв" төвийн бүсийн үзүүлэх сургалт, үзэсгэлэнд оролцуулж туршлага судлууллаа. /Хэрэгжилт - 90,0 хувь/</p>	<p>Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт аймгийн төвд ахуйн үйлчилгээний төв, сумдад цэг бий болгох зорилт дэвшүүлж ажилласаны үр дүнд төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр 8 суманд "Орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааны төв" байгуулж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх 13 бизнес төсөлд 80,0 гаруй сая төгрөгний дэмжлэг үзүүлээ. /Хэрэгжилт -30,0 хувь/</p>

22	Хөтөлбөр батлах тухай 2009,02,04 Дугаар 32 /Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр	2009-2012 2013-2016	75	<p>Хүн амыг тэжээллэг, аюулгүй хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах хэрэглээн дэх үйлдвэрийн аргаар боловсруулсан хувийн жинг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлхээр дараах ажлууд хийгдлээ. 2009 онд хүнсний үйлдвэрлэл болон хангамжийг нэмэгдүүлэхэд улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөрүүдээс нийт 3,0 тэрбум гаруй төгрөгний хөрөнгө орууллаа. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас хүнсний үйлдвэрлэл, хангамжыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 31 төсөлд 420,5 сая төгрөг, Францын "Өрхийн хүнсний хангамжын бие даасан байдлыг сайжруулах" төслөөс 11 төсөл 76.7 сая төгрөгний санхүүжилт авч төслөө хэрэгжүүлж байна. ХЯБХХН, "Атар-3" аяны шугмаар төмс хүнсний ногооны үр олгож хүлэмжийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүллээ.</p> <p>Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, хоол үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг дэмжиж аймагтаа улсын Төвийн бүсийн аймгуудын сургууль цэцэрлэгийн тогооч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх "Үдийн цай" сэдэвт ажил мэргэжлийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад олгож буй хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдлыг сайжруулхаар аймгийн Засаг даргын захирамжаар "Хүүхэд бүрт аяга сүү" аян зарлаж удирдамж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг бүх сумд холбогдох байгууллагуудад хүргүүлж хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтаар хангаж үр дүнг нь тооцож ажиллаа. Тус аяныг өрнүүлсэнээр "Үдийн цай" хөтөлбөр болон цэцэрлэг, сургуулийн дотуур байрны хүүхдийн хүнсэнд сүү цагаан эдээний хэрэглээг 60- ааш доошгүй хувьд хүргэж амин дэм эрдэс бодисын хангамжыг нэмэгдүүлсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.</p> <p>Хэрэгжилт - 90,0 хувь /</p>	2009 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн.
23	Хөтөлдбөр батлах тухай 2009,06,10 Дугаар 173 /Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр -2/	2009-2013 2013-2017	23	<p>аймгийн хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөр-2 боловсруулах, тэргүүний хоршоо шалгаруулах журам, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлууллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төсөл хөтөлбөрөөс санхүүжүүлэх байхаар тусгаж өглөө. /Хэрэгжилт 100,0 хувь/</p>	<p>2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 370 орчим гишүүнтэй, 41 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор хөдөө аж ахуйн 18, мал эмнэлгийн -5, модон материалын -4, ан агнуур, ойн аж ахуйн салбарт-2, бөөний болон жижиглэн худалдааны -7, оёдол гар урлал эсгийний -5, авто засварын -2 хадгаламж зээлийн чиглэлээр 2, хоршоо тумс тус үйл ажиллагаа явуулж байна. аймгийн хэмжээнд салбарын хоршоодын 5 холбоо ажиллаж байна. Мал аж ахуй газар тариалан хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төслийн хүрээнд Дашинчилэн сумын "Мялангийн тал", Сэлэнгэ сумын "Ингэт агро", Хутаг-Өндөр сумын "Хутагногоо" хоршоод загвар хоршоод болсон. аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тодорхой заалтуудыг оруулж хэрэгжүүлж байна. мөн сумдын Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг дүгнэхдээ хоршооны талаар хийсэн ажлыг шалгуур үзүүлэлт болгохоор гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>/Хэрэгжилт 10,0 хувь/</p>

Булган аймагт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт тухайн жилээр 84,1 хувийн биелэлттэй өссөн дүнгээр 64,3 хувийн биелэлттэй байна. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг салбараар нь авч үзвэр Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 2 хөтөлбөр тухайн жил нь 50 хувь, өссөн дүн 70 хувь, Хууль, эрх зүйн чиглэлээр 7 хөтөлбөр тухайн жилээр 92,8 хувь, өссөн дүнгээр 88,6 хувь, Батлан хамгаалах салбарт 1 хөтөлбөр тухайн жил нь 100 хувь, өссөн дүн 25 хувь, Нийгмийн бодлогын чиглэлээр 21 хөтөлбөр тухайн жил нь 83,3 хувь өссөн дүн 78,6 хувь, Хөгжлийн бодлогын чиглэлээр 24 хөтөлбөр тухайн жил нь 89,5 хувь, өссөн дүн 59,3 хувийн биелэлттэй байна. Үндэсний хөтөлбөрүүдийг хяналтанд авахдаа аймаг, сумын Засаг даргад даалгасан хөтөлбөрүүдийг авлаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР